



**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2023 ОНЫ
ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

Тайланг хянасан:

ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Төсвийн ерөнхийлөн захирагч

/Ц.ЧОГСОМЖАВ

Тайлагнасан:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА

Төсвийн шууд захирагч

/Ж.ГАНТУЛГА/

Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

Нэгжийн дарга

/Ц.ГАНЧИМЭГ/



**Засаг даргын Тамгын газрын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний
жилийн эцсийн хэрэгжилтийн дүнгийн товчоо**

Утга	Бүгд	Ковид	Хүний хөгжлийн бодлого	Эдийн засгийн бодлого	Засаглалын бодлого	Ногоон хөгжил	Аймгийн төв, сум тосгодын хөгжил	ЗГ-ын 2020 оны 206 дугаар ТОГТООЛЫН	ISO нэмэлт арга хэмжээ	
Арга хэмжээний тоо	288	5	68	66	44	17	22	13	53	
Үүнээс	100%	221	5	52	45	34	11	12	11	51
	90%	33		9	10	5	2	5	2	
	70.0%	22		4	7	3	4	4		
	50.0%	3			2	1				
	30.0%	8		2	2	1		1		2
	0.0%	1		1						
	Үнэлгээ тооцоогүй	0								
Биелэлтийн дүн /хувиар/	93.7%	100.0%	93.3%	91.6%	94.0%	91.7%	89.0%	98.4%	97.3%	

ҮНЭЛГЭЭТЭЙ ТАНИЛЦСАН:

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

/Д.ГАНТУЛГА/

ҮНЭЛГЭЭГ ХЯНАСАН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН ДАРГА

/Ц.ГАНЧИМЭГ/

ХЭРЭГЖИЛТИЙГ ҮНЭЛСЭН:

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

/Б.УНДРАХЖАРГАЛ/



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН /2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН БАЙДЛААР/

Д/д	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт/хүрээгүй бол хэрэгжилт	Хувь	ХШҮ/ %/
1	2	3	4	5	6	7	8	9
НЭГДҮГЭЭР ХЭСЭГ:								
БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГ БОЛОН ХУУЛИАР ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ АРГА ХЭМЖЭЭ								
НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛЫН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ								
Зорилт 1.1. “Ковид-19” халдварт цар тахлын хүндрэлийг хохирол багатай даван туулна.								
1	ЗДҮАХХАХТ 1.1.1. Эмнэлгийн нэг удаагийн багаж хэрэгсэл, ариутгалын бодис, эм тарианы нөөцийн бэлэн байдлыг хангана.	8 сая	Нөөцийн бэлэн байдлын хангалтын хувь	80%	85%	Эрүүл мэндийн сайдын 2023 оны А/211 тоот "Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үед эрүүл мэндийн байгууллагуудын нөөцөд байх эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, тоног төхөөрөмж, ариутгал халдваргүйтгэлийн бодис, оношлуурын жагсаалт" тушаалын дагуу эмийн 46 төрөл, эмнэлгийн хэрэгсэл 42 төрөл, нэг удаагийн хувийн хамгаалах хэрэгсэл 11 төрөл, ариутгал халдваргүйтгэлийн бодис 7 төрөл, түргэвчилсэн оношлуур 5 нэр төрлөөр тус тус нөөц бүрдүүлж, хангалт 88.3%-тай байна.	100	100

2	ЗДҮАХХАХТ1.1.2. Халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа, тандалт сэргийлэлтийн ажлыг зохион байгуулна.	-	зорилтот бүлгийн хамрагдалтын хувь	зорилтот бүлгийн хамрагдалт 53%	Зорилтот бүлгийн хамрагдалт 57%	Халдвараас сэргийлэх чиглэлээр зохион байгуулагдсан олон нийтийн ажилд 28912 иргэн, Эрүүл мэндийн байгууллагуудаар үйлчлүүлсэн 27,456 гаруй иргэнд НЭМҮТ, ЭМЯ-аас бэлтгэн гаргасан 12 төрлийн зөвлөмжийн дагуу зөвлөгөө өгч, тус тус сургалт сурталчилгаанд хамруулсан нь хүн амын 71.3%-ийг (56368 иргэн) эзэлж байна. Сургалт сурталчилгааг эрчимжүүлж ажилласнаар тарилгат халдварт өвчний тохиолдол гаргалгүй ажилласан. 2023 оны 2 сараас коронавируст халдварын 78 тохиолдол бүртгэгдэж хавьтлыг тандаж ПГУ шинжилгээг 207 хүнд хийсэн бөгөөд 8 сорьц эерэг гарч эмчилгээнд хамрагдсан. Түргэвчилсэн шинжилгээнд 70 иргэнийг хамруулж, эерэг гарсан тохиолдол бүрийг эмчилсэн.	100	100
Зорилт 1.2. Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.								
3	ЗДҮАХХАХТ1.2.1. Тохиолдлын удирдлагын тогтолцоонд суурилсан хариу арга хэмжээний төлөвлөгөөг эрсдэлийн түвшин бүрээр нарийвчлан гаргаж, тухай бүр тодотгож ажиллана.	-	Төлөвлөгөөг тодотгосон байдал, түүнтэй холбогдуулан гаргасан эрх зүйн актууд	-	Төлөвлөгөөг тодотгож, холбогдох эрх зүйн акт, хэм хэмжээг боловсруулж ажилласан байна.	Шадар сайдын 2023 оны 28-р тушаалын дагуу Тохиолдлын удирдлагын тогтолцоонд суурилсан Эрүүл мэндийн албаны хариу арга хэмжээний төлөвлөгөөнд 2 удаа тодотгол хийн хариу арга хэмжээг авч, нөхцөл байдалд эрсдэлийн үнэлгээ хийж ажилласан. "Газар хөдлөлтийн гамшиг тохиолдож ОНЦ БАЙДАЛ тогтоосон үеийн төрийн байгууллагуудын харилцан хамтын ажиллагаа" сэдэвт Стратегийн команд штабын сургуулилтад 29 эрүүл мэндийн байгууллагын эрүүл мэндийн албаны бэлэн байдлыг хангаж ажилласан. Мөн Зүүн бүсийн аймгуудын дундах "Нэг эрүүл мэнд - Зооноз" сэдэвт "Тарваган тахлын үеийн дадлага сургуулилт" амжилттай зохион байгуулагдаж, 70 гаруй эмч, мэргэжилтнийг хамруулан бэлэн байдлыг хангаж ажилласан.	100	100
Зорилт 1.3. Цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, шаардлагатай тохиолдолд зарцуулах зорилгоор гамшгийн эрсдэлийн нөөц сангийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ.								

4	ЗДҮАХХАХТ 1.3.1. Гамшгийн эрсдлийн нөөц сангийн санхүүжилтийг орон нутгийн төсвийн 1.0 хувиас доошгүйг төлөвлөж зарцуулна.	-	зарцуулсан хөрөнгийн дүн		Жилийн төсвийн 1%	Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардалд "Гамшгаас хамгаалах тухай" хуулийн дагуу орон нутгийн төсвийн 1 хувь буюу 395.8 сая төгрөгийг зарцуулахаар тооцон төсөвт тусгасан. 393.3 сая төгрөгийг гамшгаас хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд зарцуулан ажиллаж байна.	100	100
1.4. Цар тахлаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авахад зориулсан санхүүжилтийг нэмэгдүүлнэ.								
5	ЗДҮАХХАХТ 1.4.1. Орон нутгийн нөөц хөрөнгийн зардлын 30 доошгүй хувийг нэмэлтээр санхүүжүүлнэ.	-	Нэмэлт санхүүжилтийн хувиар	30	нэмэлт санхүүжилтийн хувь 30	Засаг даргын нөөц хөрөнгийн зардлыг 600.0 сая төгрөгөөр Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар батлуулсан. Үүнээс 180.0 сая төгрөгийг гамшгаас урьдчилан сэргийлэх хариу арга хэмжээ авахад зарцуулахаас Одоогийн байдлаар 127 сая төгрөгийг зарцуулан ажиллаж байна.	100	100
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ								
Эрүүл мэндийн салбар								
Зорилго 2.1. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, хянах, эмчлэх арга хэмжээг эрчимжүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд цахим системийг нэвтрүүлэн чанар хүртээмжийг сайжруулж, хамрагдалтыг нэмэгдүүлнэ.								
Зорилт 2.1.1. Нийт хүн амын 65%-ийг, зорилтот бүлгийн 70%-ийг эрүүл мэндийн боловсрол олгох сургалт, үзлэг, шинжилгээнд хамруулна.								
6	ЗДҮАХХАХТ 2.1.1.1. Сумдад нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийг жил бүр зохион байгуулна.	20 сая	Зорилтот бүлгийн хамрагдалтын хувь	Зорилтот бүлгийн хамрагдалт 55%	Зорилтот бүлгийн хамрагдалт 60%	Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөл, эмгэгүүдийг эрт илрүүлэх зорилгоор 4 бүсийн 22 суманд АНЭмнэлэг болон 3-р шатлалын эмнэлгүүдийн /АШУҮИС-ийн Япон Монголын эмнэлэг болон НАСС, УНТЭ/ нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгт нийт 21275 гаруй хүнийг хамруулсан нь зорилтот бүлгийн 60.2%-д хүрч ажилласан. Нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгийн багт дотор, мэдрэл, эмэгтэйчүүд, урологи, шүдний, БЗДХ, сүрьеэгийн үзлэг шинжилгээ хийгдсэн. Шинээр халдварт бус 229 өвчлөл, халдварт 562 өвчлөлийн тохиолдлыг илрүүлж эмчилгээнд хамруулан, эмчийн хяналтад оруулсан.	100	100

7	ЗДҮАХХАХТ 2.1.1.2. Хүн амын 70 хувийг эрдэс бодис, макро элементийн (Д, кальци) оношилгоонд хамруулж, эмчилгээний хамрагдалтыг 20-с доошгүй хувьд хүргэнэ.	18 сая	Д витамин дутагдал буурсан хувь	8.3 хувь	Хүн амын Д витамин дутал 15 хувиар буурна	Нэгдсэн эмнэлэг нь Д витамин тодорхойлох аппаратаар хангагдсанаар хүн амын дунд эрдэс бодис макро элемент тодорхойлох шинжилгээг насны ангиллаар иргэдэд тасралтгүй хийж шинжилгээний дүгнэлтийг гаргаж бүртгэлжүүлэн ажиллаж байна. Нийт 4168 үйлчлүүлэгчдэд витамин Д болон бусад макро элементүүдийн үзүүлэлтүүдийг нарийвчлан тодорхойлж, шинжилгээнд хамрагдсан иргэдийн 90 орчим хувьд Д витамин дутагдал илэрч эмчилгээнд хамрагдсан. Зорилтот бүлгийн эмчилгээний хамрагдалт 15.8%-тай байна. Хүн амын Д витамин дутагдал өмнөх оноос 9.8 хувиар буурсан.	70	70
8	ЗДҮАХХАХТ 2.1.1.3. Зонхилон тохиолдох халдварт бус өвчний анхдагч болон завсрын эрсдэлт хүчин зүйлийг бууруулах сургалт сурталчилгаанд зорилтот бүлгийн хүн амыг хамруулна.	-	Хамрагдалтын хувь	65%	67%	Зонхилон тохиолдох халдварт бус өвчний анхдагч эрсдэлт хүчин зүйлийг бууруулах чиглэлээр хүн амын дунд архи, согтууруулах ундаа, тамхины хэрэглээг бууруулах, илүүдэл жин, таргалалтаас сэргийлэх, эрүүл зөв хооллолтыг дэмжих, Осол гэмтлээс сэргийлэх чиглэлээр олон нийтийн 12 төрлийн арга хэмжээ, 13 удаагийн эрүүл мэндийн тэмдэглэлт өдрийг 28 эрүүл мэндийн байгууллагуудтай хамтарч зохион байгуулснаар нийт 32600 гаруй иргэд буюу зорилтот бүлгийн хүн амын 64.4% хамрагдсан. Хүн амын дунд зонхилон тохиолдож буй зүрх судасны өвчлөл болон хоол боловсруулах тогтолцооны өвчлөл өмнөх оны мөн үеийн түвшинд байна.	100	90
Зорилт 2.1.2. Уламжлалт анагаах ухааны тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, орон нутгийн анхан шатны эмч, мэргэжилтний 85 хувийг сургагч багшаар бэлтгэнэ.								
9	ЗДҮАХХАХТ 2.1.2.1 УАУЭмнэлгийн тусламж үйлчилгээний төрлийг нэмэгдүүлэх /зүү, засал, дотор, мэдрэл, ахмад, яаралтай тусламж/	-	Тусламж үйлчилгээний төрлийн тоо	2 төрлийн тусламж үйлчилгээ үзүүлж байна.	2 төрлийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэх	2022 онд УАУНЭ (Уламжлалт анагаах ухааны нэгдсэн эмнэлэг) нь 6 төрлийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлсэн. Мөн 2023 онд шинээр 2 төрлийн тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн, шавар эмчилгээнд 760, чихрийн шижин хөтөлбөрт эмчилгээнд 38 иргэнийг тус тус хамруулсан. Мөн мэдрэлийн тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэхээр АШУУИС-ийн МАУОУИС-ийн мэдрэлийн резидентийн 2 жилийн сургалтад 1 их эмч суралцаж байна.	100	100

10	ЗДҮАХХАХТ 2.1.2.2. Анхан шатны эмч мэргэжилтнийг уламжлалт анагаах ухааны сургагч багшаар үе шаттай бэлтгэх	-	Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний хувь	64.80%	75%	АШУУИСургууль, МУАУЭСНийгэмлэгтэй хамтран анхан шатны эрүүл мэндийн байгууллагын нийт 121 эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг "УЛАМЖЛАЛТ АНАГААХ УХААНЫ ОНОШИЛГОО, ЭМЧИЛГЭЭ, НИЙГМИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ" сэдэвт сургалтад хамруулж, сургагч багшаар бэлтгэсэн нь орон нутгийн эмч мэргэжилтнүүдийн 75 хувийг эзэлж байна.	100	100
Зорилт 2.1.3. Хеликобактеритай тэмцэх, хянах арга хэмжээг хэрэгжүүлж нянгийн шалтгаант ходоодны архаг үрэвслийг эрт илрүүлж, түүнээс үүссэн өвчлөлийн хүндрэлийг 15 хувиар бууруулна.								
11	ЗДҮАХХАХТ 2.1.3.2 Хеликобактерийн зорилтод насны хүн амын нарийвчилсан судалгааг гарган эрсдэлийг үнэлж 30-60 насны иргэдийн 60-с доошгүй хувийг оношилгоо, шинжилгээнд хамруулна.	-	Оношилгоо, шинжилгээнд хамрагдсан хувь	51.8	70%	Аймгийн хэмжээнд 30-60 насны эрсдэлт бүлгийн 16773 иргэн байна. Үүнээс анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудад 11261 иргэн хеликобактери илрүүлэх түргэвчилсэн шинжилгээнд хамрагдсан ба үүнээс эерэг гарсан 1499 иргэн аймгийн нэгдсэн эмнэлэг болон хувийн лабораторид тоолуулах шинжилгээнд хамрагдан, эмчийн хяналтад орсон. Эрсдэлт бүлгийн шинжилгээнд зорилтот бүлийн 67.1%-ийг хамруулснаар нянгийн шалтгаант ходоодны архаг үрэвсэл үүсэх өвчлөлийн хүндрэлийг 10.5%-иар бууруулсан.	95	90
12	ЗДҮАХХАХТ 2.1.3.3 Шинжилгээнд хамрагдсан иргэдийг эмчийн хяналтад оруулж, өвчлөлийн хүндрэлийг бууруулна.	-	Эмчийн хяналтад хамрагдсан хувь	28	60%	Хеликобактери илрүүлэх шинжилгээнд эерэг гарсан болон ходоод, улаан хоолойн дуранд өөрчлөлттэй гарсан 3444 иргэнийг эрт илрүүлж, хүндрэлээс урьдчилан сэргийлэн, эмчилгээнд хамруулсан. Эмчилгээний хамрагдалт 51.3% байна.	90	90
Зорилт 2.1.4. Сүрьеэ, БЗДХалдварын эрт илрүүлэлтийг эрчимжүүлэн, эмчилгээний үр дүнг 90-с доошгүй хувьд хүргэнэ.								
13	ЗДҮАХХАХТ 2.1.4.1 Сүрьеэгийн эрт илрүүлгийг зохион байгуулж, эмчилгээний хамрагдалт, чанарыг сайжруулна.	-	Эмчилгээний хамрагдалтын хувь	Сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт 92%	сүрьеэгийн эмчилгээний хамрагдалт 93%	Сүрьеэгийн шинээр 51 тохиолдол бүртгэгдсэн ба мэнд тэсвэртэй сүрьеэгийн 4 тохиолдол, түүний 252 хавьтлыг үзлэгт бүрэн хамруулж 24 хүнийг далд халдварын эмчилгээнд хамрууллаа. Аймгийн засаг даргын А/371 захирамжийн дагуу Жаргалтхаан, Цэнхэрмандал, Дэлгэрхаан сумдын эрсдэлт бүлгийн 410 иргэнд урьдчилан сэргийлэх үзлэгийг зохион байгуулсан. Эмчилгээний хамрагдалт 95.3% байна.	100	100

14	ЗДҮАХХАХТ 2.1.4.2 БЗДХ-ын эрт илэрүүлгийг эрсдэлт бүлгийн хүн амд зохион байгуулж, хавьтал илэрүүлэлтийн эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	-	Эмчилгээний хамрагдалтын хувь, хавьтал илрүүлэлтийн тоо	Эмчилгээний хамрагдалт 100%, хавьтал илрүүлэлт 0.5 байна.	БЗДХ-ын эмчилгээний хамрагдалт 100%, хавьтал илрүүлэлт 0.8	Бэлгийн замаар дамжих халдварын урьдчилан сэргийлэх үзлэгт эрсдэлт бүлгийн 4244 иргэнийг хамруулж шинэ өвчлөл 133 тохиолдлыг /тэмбүү-35, заг хүйтэн-49, трихомониаз-33/ илрүүлсэн. Илэрсэн өвчлөлийн эмчилгээний хамрагдалт 100%, хавьтал илрүүлэлт 0.7%-тай байна.	90	90
Зорилт 2.1.5. Гуравдугаар шатлалын эмнэлэгтэй хамтран зонхилон тохиолдож буй хавдрыг эрт илрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, 45-с дээш насны иргэдийн 70-с доошгүй хувийг хамруулна.								
15	ЗДҮАХХАХТ 2.1.5.2 Зонхилон тохиолдож буй хавдрыг эрт илэрүүлэх үзлэгийг гуравдугаар шатлалын эмнэлэгтэй хамтран зохион байгуулж ажиллах.	7.3 сая	45-с дээш насны иргэдийн хамрагдалтын хувь	51.5	53%	ЭМЯ, ХСҮТ, Өргөө амаржих газар, АШУҮИС-тай хамтран зонхилон тохиолдож буй хавдрыг эрт илрүүлэх үзлэг оношилгоог зохион байгуулж, эмч эмнэлгийн мэргэжилтнүүдийг чадавхжуулан ур чадварыг нэмэгдүүлж, нийт 8357 иргэнийг хавдрын эрт илрүүлэг шинжилгээнд хамруулсан. Аймгийн хэмжээнд хавдрын хяналтад 847 хүн байгаагаас 2023 оны 10 сарын байдлаар 228 шинэ тохиолдол бүртгэгдсэний 46% нь оношлогдсон. Аймгийн хэмжээнд зорилтот 45-аас дээш насны 18528 иргэн байгаагаас урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг оношилгоонд 8357 иргэн буюу 45.1%-ийг хамруулсан.	100	100
Зорилт 2.1.6. "Эрүүл ирээдүй-Эх хүүхдийн эрүүл мэнд" арга хэмжээг салбар дундын оролцоотой зохион байгуулж 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг 1 промилиор бууруулна.								
16	ЗДҮАХХАХТ 2.1.6.1. "Эрүүл ирээдүй" арга хэмжээг зохион байгуулна.	13 сая	Сөб-ийн хөтөлбөрт амны хөндийн дасгалыг оруулсан эсэх	-	Бүх СӨБ-үүд амны хөндийн дасгалыг хөтөлбөртөө тусган хэрэгжүүлж эхэлсэн байх	Аймгийн хэмжээнд 2-12 насны нийт 18855 хүүхэд байгаагаас 13312 буюу 70.6% нь хүүхдийн эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх амны хөндийн үзлэгт хамрагдсан. Үүнээс өвчлөлийн шалтгаанаар амны хөндийн өвчлөл 64,7% /шүд цоорох, шүдний гажиг, буйлны үрэвсэл/, харааны бэрхшээл /1,1%/ зонхилон тохиолдож байна. Иймд шүдний эмч нартай хамтран "Амны хөндийн эрүүл мэнд", "А,И,Ү,БЭ" дасгал, "Хамрын амьсгалын ач тус", "Зажлахын гайхамшиг", "Шүд угаах арга" сэдвүүдээр 4 сургууль, 10 цэцэрлэгийн 112 асран хамгаалагч, 44 багш нарыг ажлын байрны сургалтад хамруулсан. Үүний үр дүнд "А,И,Ү,БЭ" дасгалыг цэцэрлэгийнхээ өдөр тутмын үйл	100	100

						ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж хэвшээд байна.		
17	ЗДҮАХХАХТ 2.1.6.2. "Эх хүүхдийн эрүүл мэнд" арга хэмжээг зохион байгуулна.		5 хүртэлх хүүхдийн эндэгдлийн түвшин	15.4 промилль	14.3 промилль	"Эх хүүхдийн эрүүл мэнд" арга хэмжээний хүрээнд нярайн эрт үеийн нэн шаардлагатай тусламж үйлчилгээ болон хүүхдийн өвчний цогц менежментийн чиглэлээр 2 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 60 эмчийг хамруулан, оношилгоо, эмчилгээний ур чадварыг нэмэгдүүлэн ажилласнаар сэргийлж болох эндэгдлийг өмнөх оны мөн үеэс 3 тохиолдлоор бууруулсан. Эхийн эндэгдэл гаргаагүй ажиллаж байна. Сум, өрхийн Эрүүл мэндийн төвүүд орон нутгийн удирдлага, багийн дарга нартай хамтран "Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих 7 хоног"-ийн хүрээнд 752 эхэд "Эхийн сүүний ач холбогдол" нөлөөллийн ажлыг зохион 97%-ийг хамруулсан. Жирэмсний эрт үеийн хяналт 93.2 хувь буюу өмнөх оны мөн үеэс 0.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Нэгдсэн эмнэлгийн төрөх тасгийн нярайн эрчимт эмчилгээний тасгийг ОНТөсвийн 6 сая төгрөгийн санхүүжилтээр тохижуулж эх, нярайд ээлтэй орчныг бүрдүүлэн 84 эх, нярайд тусламж үйлчилгээ үзүүлж, биеийн байдал хүнд 17 нярайд эмчилсэн. 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 15 буюу 13.6 промилль болж өмнөх оны мөн үеэс 1.1 промилиор буурсан.	100	100
Зорилт 2.1.7. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээг хэрэгжүүлж, элэгний Д вирусийн халдвартай иргэдийн 55-с доошгүй хувийг эмчилгээнд хамруулна.								
18	ЗДҮАХХАХТ 2.1.7.1 "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний хүрээнд вирустай иргэдийн эмчилгээний хамрагдалтыг нэмэгдүүлнэ.	-	Хамрагдалтын хувь	Элэгний Д вирусийн эмчилгээний хамрагдалт 30%-тай.	45%	"Элэг бүтэн Монгол" хөтөлбөрийн хүрээнд аймгийн хэмжээнд өссөн дүнгээр 7066 иргэн түргэвчилсэн шинжилгээнд хамрагдсанаас С вирусийн халдвартай 1389, В вирусийн халдвартай 758 үйлчлүүлэгчийг илрүүлж эмчилгээд хамруулсан. Д вирус тоолох шинжилгээнд 3-р шатлалын эмнэлэгт 98 иргэнийг илгээсэн. Элэгний В, С, Д вирустэй иргэдийн эмчилгээний хамрагдалт 76.1%-тай байна.	100	90
Зорилт 2.1.8. "Эрчүүдийн эрүүл мэнд" арга хэмжээг зохион байгуулж, нийт эрчүүдийн 60-с доошгүй хувьд хүрч ажиллана.								

19	ЗДҮАХХАХТ 2.1.8.1 Эрчүүдийн эрүүл мэндэд нөлөөлж буй эрсдэлт болон эрт илэрүүлэгт хамрагдах зан зүйлд сургах нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	-	Арга хэмжээнд хмрагдсан эрчүүдийн хувь	нийт эрчүүдийн 65,1%-д нөлөөлсөн.	нийт эрчүүдийн 80%-д нөлөөлнө.	"Эрчүүдийн эрүүл мэнд" арга хэмжээний хүрээнд "Эрүүл чийрэг эр хүн", " Эр хүн та өөрийгөө хайрлаарай" аяныг төрийн болон ТББ-уудтай хамтран суугаа ажил эрхэлдэг албан хаагч, өсвөр насны хөвгүүд, аавуудыг хамруулан лекц, өдөрлөг, эмчийн үзлэгийг зохион байгуулж, 18967 эрчүүдийг хамруулж зорилтот бүлгийн 82.0%-д хүрч ажилласан. Үзлэгээр элэгний вирусийн 8, хеликобактерийн 56, түрүү булчирхайн 6 тохиолдлыг шинээр тус тус илрүүлж эмчилгээнд хамруулсан. /Аймгийн хэмжээнд 19-65 насны 23120 эрчүүд байна./	100	100
Зорилт 2.1.9. Яаралтай тусламжийн бэлэн байдал, тоног төхөөрөмж, эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн стандартын хангалтыг 10 хувиар нэмэгдүүлнэ.								
20	ЗДҮАХХАХТ 2.1.9.1 Яаралтай тусламжийн зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн стандартын хангалтыг нэмэгдүүлэх	-	Хангалтын хувь	72%	72%	Эрүүл мэндийн сайдын 2019 оны А/294 тоот тушаал болон "Яаралтай тусламжийн биксэнд байх эм, эмнэлгийн хэрэгсэл" MNS 5095:2001 стандартыг хэрэгжүүлэн ажиллаж, амилуулах суурь тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай кетамин тариаг тасалдал үүсэхээс урьдчилан сэргийлж арга хэмжээг зохион байгуулж ажилласан. Аймгийн хэмжээнд эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 90% байна.	100	100

21	ЗДҮАХХАХТ 2.1.9.2 Яаралтай тусламжийн бэлэн байдал, багаж тоног төхөөрөмжийн хангалтыг нэмэгдүүлэх	220 сая	Стандартын хангалтын хувь	Стандарт үзүүлэлттэй харьцуулахад 58.5% хангагдсан	60%	2023 онд 489.4 сая төгрөгийн 24 төрлийн тоног төхөөрөмжөөр 12 эрүүл мэндийн байгууллагыг хангасан. Үүнд: УТХОруулалтаар яаралтай тусламжийн бэлэн байдлыг хангах зорилгоор /зөөврийн ЭХО, Биохимийн анализатор, өвчтөний ор иж бүрдэл, суурин компьютер г.м/ 233.3 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжүүдийг аймгийн Нэгдсэн Эмнэлэг, Дадал, Жаргалтхаан, Бор-Өндөр, Баянхутаг, Норовлин сумдын эрүүл мэндийн төвүүдэд олгосон. ОНХО-р нэгдсэн эмнэлэг, Цэгцүүлэн дом ӨЭМТөв, Норовлин, Бэрх, Мөрөн, ЗӨСТөвд 145.5 сая төгрөгийн багаж тоног төхөөрөмжийг олгосон. Мөн ДЭМБайгууллага, НҮБ-ын дэмжлэгээр 71.1 сая төгрөгийн ариутгалын багаж хэрэгсэл, орон нутаг дахь шуурхай удирдлагын нэгжид шаардлагатай 7 нэр төрлийн 39.5 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг тус тус олгосон. Яаралтай тусламжийн багаж тоног төхөөрөмжийн хангалт 53.1% байна.	100	90
Зорилт 2.1.10. Эрүүл мэндийн байгууллагуудын шаардлагатай барилга, автомашин, багийн эмчийг унаажуулах асуудлыг үе шаттай шийдвэрлэнэ.								
22	ЗДҮАХХАХТ 2.1.10.1 Эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийг барилгын асуудлыг шийдвэрлэж чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	1.7 тэрбум	шинээр баригдсан болон өргөтгөл, засвар хийгдсэн ЭМБ-ын тоо	Байнхутаг сумын ЭМТ, нэгдсэн эмнэлгийн халдвартын эмнэлгүүд их засвар хийгдсэн.	2-с доошгүй ЭМБ-ийн шинэ барилга, өргөтгөл, засвар хийсэн байна.	2023 онд хэрэгжиж буй хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээнд 11 эрүүл мэндийн төвүүдийн барилга тусгагдсанаас Өлзийт, Хэрлэнбаян-Улаан, Өмнөдэлгэр сумын эрүүл мэндийн төвийн барилгын ажлыг 100% хийж гүйцэтгэн ашиглалтад хүлээлгэн өгсөн. Мөн Батноров, Дадал, Батширээт сумын эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгыг байнгын ашиглалтад хүлээн авсан. Галшар СЭМТөвийн барилгын ажлын явц 83%-тай, Дархан СЭМТөвийн өргөтгөлийн барилгад улсын комисс ажиллаж барилгын ажил стандартын шаардлагын дагуу хийгдээгүй тул хүлээн аваагүй бөгөөд дахин комисс ажиллахаар болсон. Биндэр сумын эрүүл мэндийн төвийн шинэ барилгын ажлын явц 95%-ийн гүйцэтгэлтэй байна.	100	100

23	ЗДҮАХХАХТ 2.1.10.2 Авто машин нэн шаардлагатай Эрүүл мэндийн байгууллагыг авто машинаар хангах	-	ЭМБ-д олгосон автомашины тоо	6 ЭМБ авто машинаар хангагдсан.	2-с доошгүй ЭМБ-ийг автомашинаар хангах	2023 онд УТХО, ОНХО-ын 138.3 сая төгрөгийн санхүүжилтээр 7 эрүүл мэндийн байгууллагад шинээр автомашин олгосон. Шинээр олгосон автомашины судалгааг шинэчлэн гаргаж, цаашид түргэн тусламжийн автомашин шаардлагатай Цэнхэрмандал, Бор-Өндөр Тахилгат, Гурванбаян эрүүл мэндийн төвийн хүсэлтийг ЭМЯ-ны хөрөнгө оруулалтын хэлтэст хүргүүлсэн.	100	100	
24	ЗДҮАХХАХТ 2.1.10.3. Багийн эмчийг унаагаар хангах	7.5 сая	Унаагаар хангагдсан багийн эмчийн тоо	2 багийн эмчийг унаагаар хангагдсан.	3 багийн эмчийг унаагаар хангах	Багийн эмчийг унаагаар хангах ажлыг сумдын Засаг дарга нарын гэрээний хавсралтад оруулан ажиллаж, 2022 онд Баянхутаг, Баян-Адарга сумуудад 14.5 сая төгрөгийн санхүүжилтээр багийн эмчийг унаажуулсан. 2023 онд Батширээт сумын Барх багийн эмчийг хандивын санхүүжилтээр унаажуулсан.	50	30	
Зорилт 2.1.11. Эрүүл мэндийн байгууллагад цахим үйлчилгээг бүрэн нэвтрүүлж, оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи ашиглаж, мэдээллийн сан үүсгэнэ.									
25	ЗДҮАХХАХТ 2.1.11.1 Аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн үйлчилгээг бүрэн цахимжуулж, мэдээллийн сан үүсгэх	-	Гүйцэтгэлийн хувь	Цахимжуулалтын ажлын гүйцэтгэл 80%	90%	Эрүүл мэндийн байгууллагууд H-info, e-health-2, Нэгдсэн эмнэлэг health.gov.mn программыг өдөр бүр үйл ажиллагаандаа ашиглаж байна. Анхан шатны ЭМБ-уудын цахим программын өөрчлөлт 7-р сараас эхлэн өөрчлөгдөж health.gov.mn-д шилжүүлэлт хийгдсэн байгаа бөгөөд сургалт, мэдээллээр 7 хоног бүр ханган ажилласнаар цахимжуулалт 93.8%-тай байна. Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол өөрчлөгдсөнтэй холбоотойгоор ЭМДЕГазраас цахимаар 2 удаа, танхимаар 1 удаа, ЭМДаатгалын тасагтай хамтран 7 хоног бүр сургалт мэдээлэл өгч ажилласан. Бор-Өндөр сумын эмнэлэг нь e-mongolia-р дамжуулан цаг захиалга, шинжилгээний хариуг авах үйлчилгээг нэвтрүүлээд байна.	90	100	

26	ЗДҮАХХАХТ 2.1.11.2 Алсын зайн технологи ашиглаж оношилгоо, эмчилгээг цаг алдалгүй хүргэх боломжийг бүрдүүлэн ажиллах	-	Алсын зайн оношилгоо нэвтрүүлсэн ЭМБ-ын тоо	3 ЭМБ шилэн кабельд холбогдсон.	4 ЭМБ-д алсын зайн оношилгоо болон мобайлыг нэвтрүүлэх	Аймгийн хэмжээнд бүх Эрүүл мэндийн байгууллагууд цахим системд холбогдон алсын зайн оношилгоогоор тусламж үйлчилгээ үзүүлэх боломж бүрдсэн. 2023 онд ДЭМБ-ээс Өмнөдэлгэр, Батширээт, Биндэр сумын Эрүүл мэндийн төв мобайл технологиор хангагдан ажиллаж байна. Нэгдсэн эмнэлэг нь алсын зайн оношилгоог ашиглан эх барих яаралтай тусламжийн чиглэлээр 1, мэдрэлийн тусламж үйлчилгээний чиглэлээр 5 удаа, сэхээн амьдруулах чиглэлээр 4 удаа телемедиценээр зөвлөгөө авч, цаг алдалгүй тусламж үйлчилгээг үзүүлсэн.	100	100
Зорилт 2.1.12. Орон нутгийн хэрэгцээ, шаардлагад нийцсэн эмийн бодлогыг хэрэгжүүлж, эмийн зохистой хэрэглээг сурталчилж, эрүүл мэндийн байгууллага бүр антибиотикийн хэрэглээнд хяналт тавих ажлыг зохион байгуулна.								
27	ЗДҮАХХАХТ 2.1.12.1 Орон нутагт эмийн бодлогыг хэрэгжүүлж, сургалт сурталчилгааг эрчимжүүлнэ.		Бодлогын хэрэгжилтийн хувь	Эмийн бодлогын хэрэгжилтийн хувь 84%	.Эмийн бодлогын хэрэгжилтийн хувь 87%-д хүрсэн байна.	2023 онд эмийн бодлогын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг 86.9%-тай хангаж ажилласан. Хурх тосгонд шинээр эмийн сангийн тусгай зөвшөөрөл олгож тосгоны иргэдийг эм, эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй, жигд, хүртээмжтэй хангах боломж бүрдсэн.	100	100
28	ЗДҮАХХАХТ 2.1.12.2 ЭМБайгууллага бүр антибиотикийн хэрэглээнд хяналт тавих ажлыг зохион байгуулна.	-	Хяналт тавьсан эмийн сангийн хувь	нийт эмийн сангийн 50%-ийг хамруулсан.	нийт эмийн сангийн 85%-ийг хамруулна.	Аймгийн хэмжээнд нийт 51 эмийн сан үйл ажиллагаа явуулж байгаагаас Хэрлэн суманд 15, бусад сум, тосгонд 36 эмийн сан ажиллаж байна. ЭЭХХЗГ, Эм холбоо, Тусгай зөвшөөрлийн комисс, холбогдох мэргэжилтнүүд хамтран 45 эмийн сангийн үйл ажиллагаа болон антибиотикийг жороор олгож буйд хяналт хийсэн нь нийт эмийн сангийн 88.3%-ийг эзэлж байна.	100	100
Биеийн тамир, спортын салбар								
Зорилго 2.2. Хүн амыг хөдөлгөөний дутагдлаас урьдчилан сэргийлэх эрүүл идэвхтэй амьдрах дадал олгох нийтийн биеийн тамирыг хөгжүүлж, спортын салбарт амжилт гаргаж, уралдаан тэмцээнд амжилттай оролцсон баг, тамирчдыг дэмжинэ.								
Зорилт 2.2.1. "Олимп" цогцолборын орчин нөхцөлийг сайжруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна.								
29	ЗДҮАХХАХТ 2.2.1.1 "Олимп" цогцолборт их засвар хийн, орчин нөхцөлийг сайжруулна.		үйл ажиллагаа тогтмолжсон эсэх	-	орчин нөхцлийг сайжруулсан байна	Олимп цогцолборын их засварыг 115,0 сая төгрөгийн хөрөнгөөр Харгуй ТӨХК хийж гүйцэтгэсэн.	100	100

30	ЗДҮАХХАХТ 2.2.1.2 Бүх нийтийн болон нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх спорт цогцолбор байгуулахад дэмжлэг үзүүлнэ.	-	Дэмжлэг үзүүлсэн эсэх	улсын төсвийн 5.8 тэр бумын хөрөнгө оруулалтаар 5 суманд спорт заал барихад дэмжлэг үзүүлсэн.	Дэмжлэг үзүүлсэн байна.	Бүх нийтийн болон нийтийн биеийн тамирыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн улсын төсөвт хөрөнгийг суулгаж өгснөөр 2023 онд Хэрлэн суманд Хэрлэн лаборатори 1-р сургуулийн спорт заал, 1 тэрбум 300 сая төгрөгийн өртөг бүхий 300 хүний суудалтай, Хэрлэн 4-р сургуулийн спорт заал, Өмнөдэлгэр 8,9 тэрбум төгрөгийн өртөг бүхий спорт заал, Жаргалтхаан суманд 8,1 тэрбум төгрөгийн өртөг бүхий сургуультайгаа цуг спорт заал тус тус Улсын төсөвт хөрөнгөөр шинээр ашиглалтад оруулж спорт цогцолборын өмнөх оноос 4-н спорт заалаар нэмэгдсэн.	100	100
Зорилт 2.2.2. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа спорт клубуудийг магадлан итгэмжлэлд оруулж, эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих нөхцөлийг бүрдүүлэн спортоор хичээллэдэг иргэдийн тоог нэмэгдүүлнэ.								
31	ЗДҮАХХАХТ 2.2.2.1 БТСГазарт бүртгэлтэй спорт клубүүдийг шат дараатайгаар магадлан итгэмжлэлд оруулна.	-	Магадлан итгэмжлэгдсэн клубын тоо	-	1-ээс доошгүй клуб магадлан итгэмжлэлд орж, спортоор хичээллэх иргэдийн тоо нэмэгдсэн байна.	"ХАДУН" фитнес клуб нь БСШУС-ын сайд, ЭМСайдын хамтарсан 2019 оны А/178, А144 тоот тушаалаар батлагдсан "Спортын клубийг магадлан итгэмжлэх журам"-ын дагуу нийтлэг шалгуур, үйл ажиллагаа явуулах орчин, эрүүл ахуйн шалгуур, сургалт - дасгалжуулалтын чанарын шалгуур үзүүлэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаанд урьдчилсан үнэлгээ хийж шаардлага хангасан тул урьдчилсан магадлан итгэмжлэлд 5 сард оруулсан ба Магадлан итгэмжлэлийн журам шинэчлэгдэж байгаатай холбоотой 2024 он хүртэл хойшилсон болно.	70	70
Зорилт 2.2.3. Нийтийг хамарсан үндэсний болон нийтийн биеийн тамир, бүх нийтийн спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагуудыг түшиглэн биеийн тамираар хичээллэгсэдийг нэмэгдүүлнэ.								
32	ЗДҮАХХАХТ 2.2.3.1. Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагыг чадваржуулах, дэмжих, төрийн зарим чиг үүргийг шилжүүлэх замаар хамтран ажиллаж, биеийн тамираар хичээллэгсдийн тоог нэмэгдүүлнэ.	-	Биеийн тамир спортын арга хэмжээнд хамрагдсан иргэдийн тоо	23 холбоонд 3000 гаруй хүн хамрагдаж байна.	Биеийн тамираар хичээллэдэг иргэдийн тоо нэмэгдсэн байна.	2023 онд БТСГазарт бүртгэлтэй 23 спортын холбоо, 15 клуб, 6 төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж биеийн тамирын чиглэлээр "Өглөөний дасгал" хөтөлбөр, "Цаг гаргая", "Цахим алхалт 2023" аяныг тус тус зохион байгуулсан ба биеийн тамирын 85 арга хэмжээнд аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 15110 иргэн хамрагдсан нь өмнөх оноос 5000-аар нэмэгдсэн байна. Биеийн тамир, спортоор хичээллэгчдийн тоог нэмэгдүүлэхэд аймгийн хэмжээнд нийт 10,800,000 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж ажилласан байна.	100	100

33	ЗДҮАХХАХТ 2.2.3.2 Үндэсний болон спортын их наадам зохион байгуулна.	60 сая	Зохион байгуулагдсан эсэх	-	Монголын бүх ард түмний спортын их наадам, хүүхдийн спортын их наадам	Монголын хүүхдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнд Хэнтий аймгийн 213 тамирчин дасгалжуулагчид спортын 17 төрлөөр амжилттай оролцож 6 алт, 6 мөнгө, 15 хүрэл нийт 27 багц медаль хүртэж багийн нийлбэр дүнгээр 7-р байрт шалгарлаа. Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.2.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Монголын Хүүхдийн спортын VII наадмын шигшээ тэмцээнд баг тамирчдыг оролцуулахад 50 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллаа.	100	100
Зорилт 2.2.4. Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааг клубийн системд шилжүүлнэ.								
34	ЗДҮАХХАХТ 2.2.4.1 Өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагааны үр дүнг тооцож, төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуй нэгж, байгууллагын хамтын ажиллагаанд уялдуулан санхүүжилтийн эх үүсвэрийг төлөвлөнө.	150 сая	Үр дүнд суурилсан эсэх	-	Үйл ажиллагаа чанаржиж, санхүүжилтийг үр дүнд суурилан олгодог болсон байна.	2022 оны Өсвөр үеийн шигшээ багийн тайланг зөвлөлийн хуралд хэлэлцүүлж, аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/03 тоот захирамжаар 150,000,000 төгрөгийг олгож, шигшээ багийн төрөлд Бокс, Хөл бөмбөгийн спортын төрлүүд шинээр нэмэгдэж, спортын 15 төрлөөр шигшээ багийн үйл ажиллагааг чанартай үргэлжлүүлэн ажиллуулж, 2023 онд төсвийн гүйцэтгэл нь дасгалжуулагчийн цалингийн зардал 108.960.000, уралдаан, тэмцээний зардал 9,420,000, НДШимтгэлийн зардал 13,620,000 шагнал урамшил 8,000,000 төгрөгийн төсвийн гүйцэтгэлтэй, спортын 15 төрөлд 386 тамирчин хичээллэж, Улс, Бүсийн 18 удаагийн уралдаан, тэмцээнд давхардсан тоогоор 752 тамирчин оролцож, нийт Алт-57, Мөнгө-54, Хүрэл-87 нийт 198 багц медаль тус тус хүртсэн амжилтыг гаргасан байна.Өсвөрийн шигшээ багийн спортын төрлүүдээр 2023 онд нийт 9 спортын төрлөөр 15 клуб үйл ажиллагаа явуулж байна	100	100
Боловсролын салбар								
Зорилго 2.3. Хүн бүрийн сурах таатай орчинг бүрдүүлж, сургалтын чанарыг дээшлүүлнэ.								
Зорилт 2.3.1. Хэрлэн сумын яслийн барилгыг 100 ороор өргөтгөж, шаардлагатай сумдын цэцэрлэгт яслийн бүлэг ажиллуулна.								

36	ЗДҮАХХАХТ 2.3.1.2. 4-оос доошгүй сумдын цэцэрлэгт яслийн бүлэг ажиллуулна.	24.3	яслийн бүлгийн тоо	4 суманд яслийн бүлэг ажиллуулж 4 бүлэгт 48 хүүхэд суралцаж байна.	1-ээс доошгүй цэцэрлэгт яслийн бүлэг нээнэ.	Норовлин сумын цэцэрлэгт 2023-2024 оны хичээлийн жилд яслийн 1 бүлэг нэмэх бэлтгэл хангаж, багш, хүүхдийн сандал, ширээ, хувцасны шүүгээг БШУЯ-ны хөрөнгө оруулалтаар авсан. Яслийн бүлэгт хамрагдах шаардлагатай 15 хүүхдийн судалгааг гаргаж, ажиллах багш нарыг товлосон хэдий ч БЕГ-аас 1 настай хүүхдийг элсүүлэхийг хориглосон шийдвэр гаргасны улмаас хичээллэх боломжгүй болсон. Норовлин, Баянхутаг, Цэнхэрмандал сумдад тус бүр 1 бага бүлэг нэмж ажиллуулан 31 хүүхдийг хамруулаад байна.	90	90
Зорилт 2.3.2. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгүүдийн гарааны үнэлгээг жил бүр шинэчлэн тогтоож сургалтын чанарыг 5,5 хувиар ахиулж үр дүнг тооцно.								
37	ЗДҮАХХАХТ 2.3.2.1. Мэргэжлийн зэрэг ахиулах, мэргэшүүлэх, түргэвчилсэн, хөрвөх сургалтыг орон нутагт зохион байгуулж, мэргэжлийн багшийн хангалтыг нэмэгдүүлнэ.	20 сая	Мэргэжлийн багшийн хангалтын хувь	СӨБ багшийн хангалт 95 хувь, ЕБС 96 хувьтай байна.	Мэргэжлийн боловсон хүчний хангалт 1 хувиар нэмэгдсэн байна.	2023 оны мэргэжил дээшлүүлэх үндсэн сургалтыг цахим болон танхимаар 8 удаа зохион байгуулж нийт 288 багш хамрагдан. Мэргэжлийн зэрэгтэй багш 477 байснаас 492 болж 3.1хувиар өссөн бол СӨБ-ын үндсэн багш 98.3% , ЕБС-ийн багшийн хангалт 98.3% тай байна. ЕБС-ийн хүний нөөцийг бүрдүүлэхийн тулд 16 сургуульд 36 ахмад багшийг үндсэн болон гэрээгээр ажиллуулж мөн дадлагажигч багш 3 ажиллаж байна.	100	100
38	ЗДҮАХХАХТ 2.3.2.2. Сургууль, цэцэрлэгийн багш нарын ажлын үр дүнг гүйцэтгэлд тулгуурлан тооцно.	8.5 сая	Чанарын ахисан байдал	-	математик сургалт 9 болон 12 ангийн сургалтын чанар 35,5%, байгалийн ухааны сургалтын чанар 37,5%-д хүрсэн байна	Судлагдахуунд суурилсан мэргэжлийн хөгжлийн бүлгийн үйл ажиллагаагаар математик, байгалийн ухааны багш нар нийт 81 удаагийн цахим уулзалтаар багшийн гүйцэтгэлийн үнэлгээний хоцрогдолтой агуулгатай ажиллаж онолын мэдлэг болон ээлжит хичээлийн чанарын үр дүн мөн заах барил чадварыг нэмэгдүүлэн ажилласан. Гүйцэтгэлийн үнэлгээгээр 9 болон 12 ангийн математикийн сургалт 41,1 болж 5,6 өссөн, 9 болон 12 ангийн Байгалийн ухааны сургалт 37,8 болж 0,3 хувиар тус тус өссөн үзүүлэлттэй байна.	100	100

39	ЗДҮАХХАХТ 2.3.2.3 Аймгийн бүх сургууль, цэцэрлэгүүдээс гарааны үнэлгээ тогтоож, чанарын шалгалт авна.	5 сая	чанарын хувь	ЕБС сургалтын чанар 44.5 хувьтай, СӨБ-ын сургалтын чанар 80.7 хувьтай байна.	ЕБС, СӨБ-ын сургалтын чанарыг 1.4 хувиар ахиулна.	Багшийн гүйцэтгэлийн үнэлгээнд 27 сургуулийн 588 багш хамрагдвал зохих 10752 хүүхдийн түүвэр ирснээс 10112 буюу 94,3 хувь хамрагдаж Боловсролын үнэлгээний төвөөс зарласан дүнгээр ЕБС сургалтын чанар 52,75 буюу өмнөх оноос 12,8 хувиар ахисан. Сургуульд бэлтгэгдсэн байдлын судалгаанд үзүүлсэн дүнг үзэхэд СӨБ-ийн сургалтын чанар 73 хувь буюу өмнөх оноос 5,99 хувиар буурсан.	90	70	
Зорилт 2.3.4. Судалгаанд үндэслэн зарим сургуулийн хэв шинжийг өөрчилнө.									
40	ЗДҮАХХАХТ 2.3.4.1 Судалгаа, сургалтын чанар, ажлын үр дүнгийн үзүүлэлт зэргийг харгалзан шаардлагатай сургуулийн хэв шинж, бүтцийг өөрчилнө.	-	Хэв шинж өөрчилсөн сургуулийн тоо	-	9 жилийн сургуулиудад хяналт шинжилгээ хийж шаардлагатай сургуулийн хэв шинжийг өөрчилнө	Аймгийн Засаг даргын 2023 оны А/24 тоот захирамжаар Бор-өндөр цогцолбор сургуулийн ангилалд өөрчлөлт оруулан дунд, ахлах ангийн сургалтын үйл ажиллагааг явуулахаар өөрчилж, Бор-өндөр бага сургуулийг шинээр байгуулсан, мөн А/322 тоот захирамжаар Хэрлэн лаборатори нэгдүгээр сургуулийн 2-р байрыг түшиглэн Байгалийн ухаан технологийн гүнзгийрүүлсэн сургалттай Хэрлэн 5-р сургуулийг шинээр байгуулж хэв шинжийг өөрчилсөн. Хэрлэнбаян-улаан тосгоны ЕБС болон цэцэрлэгийг цогцолбор болгох захирамж гарсан ч тодорхойгүй хугацаагаар хойшилсон.	100	100	
Зорилт 2.3.5. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн багш, ажилтны нийгмийн болон хөдөлмөрийн үнэлэмжийг нэмэгдүүлэх зорилгоор “Чадварлаг багш, чанартай боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ.									

41	ЗДҮАХХАХТ 2.3.5.1 Чадварлаг багш чанартай боловсрол Арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлнэ.	26 сая	-	100 хувь	Чадварлаг багш арга хэмжээний хүрээнд сургуулийн менежментийг сайжруулах ажлыг БШУ-ны яам, БЕГ, БСҮХ, БҮТ-тэй хамтарсан баг Хэрлэн сумын 4 дүгээр сургууль, Өмнөдэлгэр сумын ЕБС дээр зохион байгуулж уг ажлын хүрээнд 2 удаагийн зөвлөн туслах ажлыг хийж давхардсан тоогоор 14 судлагдахууны 128 багшийн хичээлд сууж 12 судалгаат хичээл зааж багш, суралцагч, удирдах ажилтнуудтай фокус ярилцлага хийж асуудлаа тодорхойлон ажиллаж байна. Арга хэмжээний хүрээнд ЭЕШ тэргүүлсэн 3 сургууль, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр шалгарсан 3 сургууль, 3 цэцэрлэг, 3 мэргэжлийн хөгжлийн бүлэг, 45 багш, анги удирдсан 31 багш, ур чадварын уралдаанд амжилттай оролцсон 3 багш, STEM сургалтын амжилттай нэвтрүүлсэн 3 сургалтын менежерийг 14.3 сая төгрөгөөр шагнаж урамшууллаа	100	100	
Зорилт 2.3.6. Орон нутагт шаардлагатай мэргэжлээр суралцаж байгаа оюутнуудад сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлнэ.								
42	ЗДҮАХХАХТ 2.3.6.1 "Сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлэх журам"-ын дагуу шаардлагатай мэргэжлээр суралцаж буй оюутнуудын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлнэ.		дэмжлэг үзүүлсэн эсэх	журам шинэчлэгдэж байна	Сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлсэн байна.	2023 онд 12 дугаар анги төгссөн суралцагчдаас МУБИС-д 32 оюутан элсэн суралцаж байна. Үүнээс 8 оюутан 70 хувийн тэтгэлэгтэйгээр суралцаж байна. БШУГазрын сургалтын танхимд тус оюутнуудад ЗӨГИЙН ҮҮР хөтөлбөрийн талаарх мэдээллийг өгч ажилласан. Уг хөтөлбөрт 2023 онд Математикийн багш 1, Химийн багш 2, Бага ангийн багш 2 нийт 14 сая төгрөгийн сургалтын төлбөрийн дэмжлэг авсан.	100	100
Зорилт 2.3.7. Боловсролын байгууллагын удирдах албан тушаалтнуудын мэдлэг боловсролыг дээшлүүлэх сургалтыг жил бүр зохион байгуулж, сургалтын үр дүнг ажлын гүйцэтгэл дээр тулгуурлан үнэлж дүгнэнэ.								

43	ЗДҮАХХАХТ 2.3.7.1 Удирдах ажилтнуудын сургалтыг зохион байгуулж, үр дүнг ажлын гүйцэтгэлд тулгуурлан тооцно	10 сая	үр дүн тооцсон эсэх	Жил бүр зохион байгуулдаг 4 үр дүнг тооцохгүй байна.	2-оос доошгүй удаа зохион байгуулж, үр дүнг тооцсон байна.	Боловсролын байгууллагын удирдлагын менежмент, хүүхэд хөгжил, хамгааллын ажлын үр дүнг сайжруулах оролцоонд тулгуурласан хүүхэд хөгжил хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, сургуулийн хүүхэд хамгааллын багийн гишүүдийг чадавхжуулах зорилготойгоор Удирдах ажилтны зөвлөгөөнийг зохион байгуулж 69 хүнийг хамруулан арга зүйн дэмжлэг үзүүлэн ажиллалаа. Мөн боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилтийг хангах, багшийн болон байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнд шинжилгээ хийх чиглэлээр холбогдох хүмүүсийг урьж оролцуулан 500 багш, удирдах ажилтныг хамруулан 2 дахь зөвлөгөөн зохион байгуулсан. Үр дүнд нь сургуулийн менежментийг хэрэгжүүлэх зураглал гаргасан. Улсын хэмжээнд туршиж буй цэцэрлэгийн менежментийг сайжруулах ажлыг Хэрлэн 9 р цэцэрлэг, ЕБС менежментийг Хэрлэн 4, Өмнөдэлгэр ЕБС хэрэгжүүлэн тайланг БЕГ хүргүүлсний дүнд хангалттай үнэлэгдсэн. 2024 онд 8 сургуульд сургуулийн менежментийг хэрэгжихээр болсон	100	100
Зорилт 2.3.8. Шаардлагатай сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцөлийг сайжруулж зориулалтын тоног төхөөрөмжөөр хангана.								
44	ЗДҮАХХАХТ 2.3.8.1 Нүхэн жорлонтой цэцэрлэг, сургууль, дотуур байрыг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгох ажлыг шат дараатай хийж, хүүхдэд ээлтэй орчин бүрдүүлнэ.	28.5	нэмэгдсэн АЦБ, тоног төхөөрөмжийн тоо		АЦБ-ийг 1-ээс доошгүй СӨБ, ЕБС-ийг цэцэрлэгийг орчин үеийн ариун цэврийн өрөөтэй болгоно	БШУЯамнаас зарлагдсан АЦБ-ийг шинэчлэх төслийн 3-р ээлжид хамрагдсан 5 сургууль, 2 цэцэрлэг, 5 дотуур байрыг ашиглалтад оруулсан мөн Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар сургууль 6, дотуур байр -3, цэцэрлэг-1 барилгын их засварын ажил хийгдэж дууссанаар ариун цэврийн тохилог байгууламжтай болоод байна.	100	100
Зорилт 2.3.10. Бүх насны суралцагч, иргэдэд зориулсан онлайн сургалтын сантай болж, цахим сургалт зохион байгуулж, иргэдийн 30 хувьд хүрч ажиллана.								
45	ЗДҮАХХАХТ 2.3.10.1 Боловсролын салбарын цахим платформын хүрээнд ЕБС-ийн цахим хичээлийн санг нэмэгдүүлнэ.	-	нэмэгдсэн байдал	25 сургууль хамрагдсан байна	цахим шилжилтэд хамрагдсан сургуулийн тоо 1-ээр нэмэгдсэн байна.	Аймгийн 27-н сургууль нөхөн хангалтын зардлаараа интернэт төхөөрөмж худалдан авч цахимд 100% шилжээд байна. 25 сургууль нь цахим ангитай болсноор англи хэлний Пийрсон хөтөлбөр, Математикийн Эдүтэн хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж байна. Математикийн 15 нэгж цагийн хичээлийг medle талбарт байршуулсан.	100	100

46	ЗДҮАХХАХТ 2.3.10.2. Цахим хичээлийг онлайнаар болон Фэйсбүүк, байгууллагын цахим хуудсаар дамжуулан явуулж, иргэдийн 30 хувьд хүрч ажиллана.	-	хувиар	27%	Нийт иргэдийн 30 хувьд сургалт зохион байгуулна.	Насан туршийн боловсролын төв болон сум, тосгоны насан туршийн боловсрол хариуцсан 32 багшийг БЕГазрын Насан туршийн боловсролын хэлтсээс зохион байгуулсан "Цахим ур чадвар" олгох сургалтад хамруулж сургагч багшаар бэлтгэлээ. Сургагч багш нараар дамжуулан орон нутгийн иргэдэд "Цахим шилжилтийн тухай ойлголт", "Цахим хөгжил, харилцаа" сургалтыг зохион байгуулж давхардсан тоогоор 24893 иргэнд хүрч ажиллаа. Мөн байгууллагын пэйж хуудас дээр 3 төрлийн хичээл байршуулан 19230 хүний хандалт аваад байна. нийт иргэдийн 25 хувьд сургалт зохион байгуулсан. 18 сумын 80 байгууллагын 1736 албан хаагч монгол бичгийн сургалтад хамрагдаж байна. төрийн байгууллагын 42,1 хувийг сургалтад хамруулсан үзүүлэлттэй байна.	100	100
Зорилт 2.3.11. Багш хөгжлийн төв байгуулж, насан туршийн боловсрол төвийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, орчин нөхцлийг сайжруулна.								
47	ЗДҮАХХАХТ 2.3.11.1. Багш хөгжлийн төв барих зураг төсвийг боловсруулж, холбогдох газарт саналаа уламжилж шийдвэрлүүлнэ.		Зураг төсөв боловсруулсан эсэх		Багш хөгжлийн төвийн барилгын ажил дууссан байна.	Багш хөгжлийн төвийн барилгын зураг төсвийг хийж батлуулан, Сангийн яамны хөрөнгө оруулалтын системд 2023, 2024 онуудад санал оруулсан боловч дэмжигдээгүй.	30	0
48	ЗДҮАХХАХТ 2.3.11.2. Насан туршийн боловсрол төвийн орчин нөхцлийг сайжруулна.		Сайжруулсан эсэх		Багш хөгжлийн төвд үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна.	Насан туршийн суралцахуйн төв нь захирал 1, сургалтын менежер 1, нийгмийн ажилтан 1, багш 6, нягтлан бодогч 1, бичиг хэргийн ажилтан 1 нийт 11 албан хаагчийн бүрэлдэхүүнтэйгээр Хэрлэн 5-р сургуулийн байранд сургалт хүмүүжлийн үйл ажиллагаагаа тогтмол явуулж байна. 2024 оны орон нутгийн төсвийн төсөлд санхүүжилтийг тусгасан боловч дэмжигдээгүй. Тогтмол зардал нь шийдвэрлэгдсэн.	30	30
Зорилт 2.3.12. Суралцагчдын мэдээлэл технологийн чадварыг сайжруулах зорилгоор ЕБС-ийн 1 компьютерт ногдох хүүхдийн тоог бууруулж, сургуулиудын интернэт хурдыг нэмэгдүүлнэ.								

49	ЗДҮАХХАХТ 2.3.12.1. ЕБС-иудын суурин компьютерийн тоог үе шаттайгаар нэмэгдүүлнэ.	-	буурсан байдал	1 компьютерт ногдох хүүхдийн тоо 17 байна.	ЕБС-ийн нэг компьютерт ногдох хүүхдийн тоо буурсан байна.	Ерөнхий боловсролын 27 сургуульд цахим танхим байгуулах ажлын хүрээнд 881.2 сая төгрөгөөр суурин компьютер 68 ширхэг, зөөврийн компьютер 18 ширхэг, таблет 750 ширхгийг авч цахим сургалт зохион байгуулах танхим байгуулаад байна. Ингэснээр нэг компьютер, таблетэд ногдох хүүхдийн тоо 6.57 болж өмнөх оноос 61.7 хувиар бууруулсан.	100	100
----	---	---	----------------	--	---	---	-----	-----

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар

Зорилго 2.4. Нийгмийн хамгааллыг оновчтой хүртээж, хүн амын хөгжлийг ханган хөдөлмөр эрхлэлтийн түвшинг 5-аас дээш хувиар нэмэгдүүлнэ.

2.4.1. Иргэдэд нийгмийн даатгалын ач холбогдолыг сурталчлан даатгуулагчдын тоог нэмэгдүүлнэ.

50	ЗДҮАХХАХТ 2.4.1.1 Нийгмийн даатгалын багц хуулийг даатгуулагчдад сурталчлах сургалт, нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулах	-	зохион байгуулсан сургалтын тоо, хамрагдсан иргэдийн тоо, сайн дураар даатгуулагчийн тоо	310 удаагийн сургалт ад 17202 иргэд даатгуулагчийг хамруулж, сайн дурын даатгалд 1383 даатгуулагч хамрагдсан.	Сургалт сурталчилгаанд хамрагдах даатгуулагчийн тоог жилд 5 хувиар, сайн дурын даатгалд шинээр 1200-с доошгүй даатгуулагчийг хамруулна.	2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн хэрэгжиж буй хуулийн өөрчлөлтийн талаар аж ахуйн нэгж, иргэд даатгуулагчдад зориулсан сургалт сурталчилгаанд 305 ажил олгогчийн 4625 албан журмын даатгуулагч, 90 багийн 6231 малчин, хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэд, малчин даатгуулагчид хамрагдаж зөвлөмж, зөвлөгөө, сургалт хийж нийт 10856 иргэд, даатгуулагчдыг хамруулсан. Нийгмийн даатгалын ач холбогдлыг иргэд даатгуулагчдад танин мэдүүлэх талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр давтагдсан тоогоор 1214 постер мэдээлэл, сурталчилгааг хүргэсэн бөгөөд 85181 иргэдийн хандалт авсан байна. Сайн дурын даатгалд 4521 даатгуулагч хамрагдсанаас шинээр 1125 даатгуулагч хамрагдсан байна.	100	100
97	ЗДҮАХХАХТ 3.3.2.5. Хүнсний ногоо газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдэд хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлэх сургалыг зөвлөгөөн зохион байгуулах	1.5	оролцогчдын болон ХААЗД нэвтрүүлсэн ААН-ийн тоогоор		100 хүртэл үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулж, хөдөө аж ахуйн зохистой дадал нэвтрүүлсэн ААН-ийн тоог нэмэгдүүлнэ.	Тариаланч, ногоочдын зөвлөгөөнд нийт 111 тариалан эрхлэгчид ногоочид оролцсон. Мөн АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлаг (USAID)-ийн санхүүжилттэй Бизнесийн Тогтвортой Хөгжлийг Сайжруулах, Ил Тод Байдлыг Нэмэгдүүлэх (BEST) хөтөлбөрийн хүрээнд Хүлэмжийн зохистой дадлын ойлголт, хэвшүүлэх шаардлага, ач тус, арга замын талаар ойлголт, мэдээлэл өгөх зорилгоор "ХҮЛЭМЖИЙН АЖ АХУЙН ЗОХИСТОЙ ДАДАЛ" сургалтыг 2023.01.16-ны өдөр зохион байгуулж тус сургалтад Хэрлэн, Мөрөн, Бэрх тосгоны 15 ногоочдын хамрагдаж зохистой дадлын хугацаа дууссан 1 аж ахуйн нэгж, 2 хоршооны хугацааг сунгуулсан.	100	90
Зорилт 3.3.3. Малын тоог чанарт шилжүүлэх, ашиг шимийг нэмэгдүүлэх, эрчимжсэн мал аж ахуйг дэмжиж, "Монгол мал-II" арга хэмжээг хэрэгжүүлнэ.								
98	ЗДҮАХХАХТ 3.3.3.1. Арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан үе шаттай хэрэгжүүлнэ.	32	хэрэгжилтийн хувиар	Төлөвлөсөн арга хэмжээг 90 хувьтай хэрэгжүүлж ажилласан.	Арга хэмжээ 90-ээс дээш хувьтай хэрэгжсэн байна.	Монгол мал-II" арга хэмжээг хэрэгжүүлэх 14 арга хэмжээг төлөвлөж, 2023 онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг 92 хувьтай хэрэгжүүлж ажилласан. Үүнд: Хүнс, Хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн 2023.10.16-ны өдрийн хуралдаанаар Хэнтий аймгийн Дадал суманд үржүүлж буй Махсүүний хосолмол ашиг шимтэй дадлын ухаа үхрийг "Дадалын ухаа" үүлдэрээр батлуулсан. ОНТөсвийн 12.8 сая төгрөгийн хөрөнгөөр баталгаажсан үүлдэр омгийн 7.2 мян.тол малд үзлэг ангилалт хийж, 790 толгой малыг эзэмгжүүлж, бүртгэлжүүлсэн. Ангилалтад хамрагдсан нийт малын 33.0%-г цөм сүрэгт, 55.7%-г үржлийн сүрэгт, 11.3%-г хэрэгцээний сүрэгт тус тус бүртгэсэн. Улсын төсвийн 37.5 сая төгрөгийн хөрөнгөөр Батширээт, Дадал, Батноров, Норовлин сумдын 41 өрх, 2 аж ахуйн нэгжийн 267 үнээнд Геррефорд, 180 үнээнд Ангус, 280 үнээнд Симменталь үүлдрийн бухын гүн хөлдөөсөн үрээр, нийт 727 үнээнд зохиомол хээлтүүлэг хийсэн.	100	100

Зорилт 3.3.4. Мал эмнэлгийн үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэх, оношилгоо шинжилгээний чадавхийг нэмэгдүүлэн малын гаралтай халдварт, гоц халдварт өвчний гаралтыг бууруулна.

99	3.3.4.1. Мал эмнэлгийн лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулж, үйлчилгээ, оношилгооны чанар, хүртээмжийг дээшлүүлнэ.		Ажлын гүйцэтгэл, чанар, дүнгээр үр	Малын өвчний оношлогооны баталгаажуулалт 100% үр дүнтэй болсон.	9 төрлийн багаж тоног төхөөрөмж худалдан авсан байна	Аймгийн Мал эмнэлгийн лабораторид флуоресценцийн микроскоп, ус нэрэгч, хатаах шүүгээ, овоскоп гэх 4 төрлийн багаж, тоног төхөөрөмжийг 41.8 сая төгрөгөөр худалдан авсан. Лабораторийн тоног төхөөрөмжийг сайжруулснаар шинжилгээ цаг хугацаа алдалгүй хийгдэж, малын өвчний оношилгооны баталгаажуулалт 100% үр дүнтэй болсон	90	90
100	ЗДҮАХХАХТ 3.3.4.2. Сумдын МЭТасагт шаардлагатай лабораторийн тоног төхөөрөмжийн дэмжлэг үзүүлнэ.	-	тоогоор	6 сумын МЭТасагт дэмжлэг үзүүлсэн.	6 сумын МЭТасагт дэмжлэг үзүүлсэн байна.	7 сум мал эмнэлгийн үйлчилгээнд шаардлагатай тарилгын хашаа, зөөврийн сууц, лабораторийн багаж хэрэгсэл зэрэг тоног төхөөрөмжийг 485.1 сая төгрөгийн төсөвт өртгөөр худалдан авалт хийж сумдын МЭТасгийн үйлчилгээг дэмжиж ажиллаа.	100	100
101	ЗДҮАХХАХТ 3.3.4.3. Голомтлон гардаг 5 төрлийн халдварт өвчнүүдээс урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, малаас хүнд халдварладаг халдварт, гоц халдварт өвчнүүдийн голомтуудыг жил бүр ариутгах ажлыг зохион байгуулна.	3.0	Халдварт өвчний гаралт өмнөх жилээс буурсан тоо, хувиар	2020 онд халдварт өвчний гаралт 47 голомтод байсан.	Халдварт өвчний гаралт өмнөх жилээс буурсан байна.	4 төрлийн халдварт өвчний өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 595.0 мянган мал хамруулахаас 559.8 мянган мал хамруулж гүйцэтгэл 94.1 хувьтай хийгдсэн. Малаас хүнд халдварладаг галзуу, боом болон бог малын мялзан, хонины цэцэг өвчний нийт 658.9 мян.м ² талбайд голомтыг халдваргүйтгэх ажлыг Мал эмнэлгийн тасаг, үйлчилгээний нэгжүүд хамтран гүйцэтгэсэн халдварт өвчний гаралт өмнөх оноос 40%-иар буурсан.	100	100

Зорилт 3.3.5. Бэлчээр хамгаалалт, ашиглалтыг сайжруулан, өвс тэжээлийн нөөц бүрдүүлэлт, усан хангамжийг нэмэгдүүлнэ.

102	ЗДҮАХХАХТ 3.3.5.1. Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг тогтмол явуулах тоног төхөөрөмжөөр хангана.	10.0	хувиар	хур тунадсыг 51.2 хувиар нэмэгдүүлсэн.	Цаг агаарын нөхцөл бүрдсэн үед хур тунадасны хэмжээг нэмэгдүүлж ажиллана.	2023 онд 8 удаагийн процесст 2 хөдөлгөөнт экспедици 14 удаа цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэн ажилласан. Дулааны улиралд аймгийн ихэнх нутгаар хур тунадас олон жилийн дунджаас ахиу тунадас орсон. Хэрлэн, Өлзийт, Хурх тосгон орчмоор дунджийн орчим хур тунадас орсон. ЦУОШГ-аас цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадас нэмэгдүүлэх үйл ажиллагааг" үр дүн сайтай ажилласан гэж дүгнэгдсэн. Тунадасны хэмжээг 21.8%-иар нэмэгдүүлсэн.	100	100
-----	---	------	--------	--	---	---	-----	-----

103	ЗДҮАХХАХТ 3.3.5.2. Үлийн цагаан оготно устгалын ажлыг зохион байгуулж, бэлчээрийг хамгаална.	45.0	тоогоор	7 суманд 25.2 мянган га-д устгал хийсэн.	6 сумын 60.0 мянган га-д хийнэ	Улсын төсвийн 40.0 сая.төг, малын тоо, толгойн албан татварын 25.5 сая.төг, нийт 65.5 сая төгрөгийн хөрөнгөөр 9 сумын 46.2 мянган га бэлчээрт энгийн механик болон микробиологийн аргаар бэлчээрийн хөнөөлт мэрэгч үлийн цагаан оготнотой тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлсэн.	70	70
104	ЗДҮАХХАХТ 3.3.5.3. Тал хээрийн бүсийн сумдад инженерийн хийцтэй худаг, хөв цөөрөм бий болгоно.	250.0	шинээр гаргасан худгийн тоогоор	28 гүн өрмийн худаг гаргасан	3-аас доошгүй инженерийн хийцтэй худаг гаргасан байна.	Улсын төсвийн 120.0 сая.төг, малын тоо толгойн албан татварын 489.6 сая.төг, малчдын санхүүжилт 100.0 сая.төг, нийт 709.6 сая төгрөгийн хөрөнгөөр 16 суманд 47 худаг шинээр гаргаж, 70.5 мянган га бэлчээрийг усжуулсан.	100	100
Зорилт 3.3.6. Гарааны бизнес эрхлэгчид, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгч хувийн хэвшлийн санал санаачилгыг хөнгөлөлттэй зээлийн бодлогоор дэмжиж, борлуулалтын сүлжээг нэмэгдүүлнэ.								
105	ЗДҮАХХАХТ 3.3.6.1. Чингис хот дахь гарааны бизнес эрхлэгчдийг бойжуулах "Бизнес инкубатор төв"-ийн үйл ажиллагааг идэвхжүүлнэ.	-	тоогоор	бгарааны бикнес эрхлэгчийг дэмжиж, 3 ажлын байрыг бий болгосон.	4-с доошгүй үйлдвэрлэл эрхлэгчдийг бойжуулна.	2023 онд Хүнс, хөдөө аж ахуйн газар шинэ байртай болсноор хуучин хүнс, хөдөө аж ахуйн байранд Бизнес Инкубатор төв шинээр бий болж, тус төвүүдэд 2 аж ахуйн нэгж, 7 иргэн бойжиж байна. БИТ-н 3 бойжигчийг Хоршоо хөгжүүлэх сангаас 75.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлд хамруулсан. Best хөтөлбөрийн тэтгэлэгт сонгон шалгаруулалтаас 1 аж ахуйн нэгж 10 сая төгрөгийн буцалтгүй тэтгэлэгт шалгарч үйл ажиллагаагаа явуулж байна. Гарааны бизнес эрхлэгчдийг Best хөтөлбөрийн үе шаттай сургалтад хамруулахаас гадна ЖДҮГазар, Монгол банкны хамтарсан "Санхүүгийн анхан шатны" боловсрол олгох 2 удаагийн сургалтад хамруулан чадавхжууллаа.	100	100
106	ЗДҮАХХАХТ 3.3.6.2 "Хэнтийн намрын ногоон өдрүүд", "Цагаан сар-Цагаан идээ" үзэсгэлэн худалдааг жил бүр зохион байгуулна.	10.0	хувиар	-	18 сум, 5 тосгоны үйлдвэрлэгчдийг хамруулна.	"Цагаан сар-Цагаан идээ, Өвлийн идэш-2023" нэгдсэн арга хэмжээнд 18 сум, 5 тосгоны 53 аж ахуй нэгж, 70 иргэн 228 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 142.8 сая төгрөгийн борлуулалт, "Хэнтийн намрын ногоон өдрүүд-2023" нэгдсэн арга хэмжээнд 18 сум, 4 тосгоны 175 иргэн, 75 аж ахуйн нэгж 180 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 51.6 сая төгрөгийн борлуулалт хийж, төв суурин газрын хүн амын хүнсний хангамжид орон нутагт үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн нийлүүлж, үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжин ажилласан.	100	100

107	ЗДҮАХХАХТ 3.3.6.3. Төрийн байгууллагууд, томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хоол үйлдвэрлэлд нийлүүлэх хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчдээс худалдан авах ажлыг зохион байгуулна.	-	хувиар	2022 онд төрийн байгууллагууд, томоохон уул уурхайн ААН-ийн хоол үйлдвэрлэлд 1,2 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүнийг дотоодын үйлдвэрлэгчдээс худалдан авсан.	Дотоодын үйлдвэрлэлийн хүнсний бүтээгдэхүүний хангамжийн хэмжээг нэмэгдүүлж, борлуулалтыг сайжруулна.	Дотоодын үйлдвэрлэл эрхлэгч 75 аж ахуйн нэгж, 130 иргэнээс Бор-Өндөр сум болон Бэрх тосгонд үйл ажиллагаа явуулдаг 5 уурхайд 35.0 сая төгрөгийн хүнсний ногоо, 18 сум, 5 тосгоны 27 сургууль, 35 цэцэрлэг, 1 яслийн үдийн цайнд 650.7 сая төгрөг, 18 сумын ЭМТөвд 590.0 сая төгрөг, аймгийн ШШГГазарт 76.0 сая төгрөг, нийт 1.3 тэрбум төгрөгийн хүнсний бүтээгдэхүүн нийлүүлж дотоодын үйлдвэрлэлийг дэмжин ажилласан.	100	100	
108	ЗДҮАХХАХТ 3.3.6.4. Хаврын улиралд шаардлагатай махны нөөц бүрдүүлсэн аж ахуйн нэгжид урамшуулал олгох замаар махны үнийн тогтвортой байдлыг хадгална.	80	тоогоор	2022 онд 30,9 тн маханд нөөцийн урамшуулал олгосон.	60 тн-оос багагүй махны нөөц бүрдүүлж, үнийн тогтвортой байдлыг хадгалсан байна.	Хаврын улиралд хүн амыг махны хомсдол, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор 60 тн нөөцийн мах нийлүүлж 80.0 сая төгрөгийн урамшуулал олгосон. 2023 онд 60 тн мах бэлтгэхээр төлөвлөж Хэрлэн, Норовлин, Баян-Адарга, Өмнөдэлгэр сумын 9 аж ахуйн нэгж үхрийн мах 450 тн, хонины мах 540 тн, ямааны 360 тн-ыг тус тус бэлтгэн нөөцлөөд байна. Нөөцийн махыг зах зээлийн үнээс хямд борлуулж үнийн тогтвортой өсөлтийг ханган ажиллаж байна.	100	100	
109	ЗДҮАХХАХТ 3.3.6.5. Анхан шатны боловсруулах үйлдвэрүүдийг хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр дэмжинэ.	-	тоогоор	2022 онд 5 аж ахуйн нэгж, 1 иргэнд 957,0 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж 11 ажлын байр шинээр бий болгосон.	5-с доошгүй иргэн, аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлж, 15-с доошгүй ажлын байр бий болгосон байна.	Мөрөн, Норовлин, Биндэр, Батноров, Бор-Өндөр сумдын 4 хоршоо, 9 иргэнд анхан шатны боловсруулах үйлдвэрлэлийн зориулалтаар Хоршоо хөгжүүлэх сангаас 425.0 сая төгрөгийн зээлийг сонгон шалгаруулж олгосон байна. Энэхүү төсөлд 30 ажлын байр бий болоод байна.	90	100	
Түүхэн аялал жуулчлал хөгжил									
Зорилго 3.4. "Тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төсөл-1"-ийг хэрэгжүүлж, Түүхэн аялал жуулчлал, үндэсний онцлог шингэсэн арга хэмжээнүүдийг сурталчилна.									
Зорилт 3.4.1. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрутын дагуух сумдад байгаль орчинд ээлтэй, нутгийн иргэд /өрх/-ийг түшиглэсэн тогтвортой, эко аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоог 10 хувиар нэмэгдүүлнэ.									
110	ЗДҮАХХАХТ 3.4.1.1 Нутгийн брэнд, эко бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийг чадавхжуулах сургалтад хамруулж, тогтвортой, эко аялал	4.0	хувиар	Аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч ААН 9.7 хувиар нэмэгдсэн.	Шинээр аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн тоог 2-оос доошгүй хувиар нэмэгдүүлнэ.	Зүүн бүсийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн нэгдсэн сургалт, үзэсгэлэн арга хэмжээг Чингис хотод зохион байгуулж, 15 сум, 2 тосгоны 80 гаруй хүнс, гар урлалын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгч аж ахуй нэгж, иргэд оролцлоо. Түүхэн аялал жуулчлалын маршрутын дагуу Дадал суманд шинээр 2 отоглох цэгийг гэрээгээр орон нутгийн иргэдийн бүлэгт	100	100	

	жуулчлалыг хөгжүүлнэ.					эзэмшүүлсэн. Мөн 4 сумын 9 иргэн гэр буудал ажиллуулж, 3 аж ахуй нэгж үйл ажиллагаагаа өргөтгөж, Бор-Өндөр суманд гар урлал, бэлэг дурсгалын брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг 1 иргэний гарааны бизнест дэмжлэг үзүүлж аялал жуулчлалын эко бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг шинээр бий болгон гадаад дотоодын амрагч, аялагч жуулчдад үйлчилгээ үзүүлж байна. Шинээр аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэд, ААН-ийн тоо 7 хувиар нэмэгдээд байна.		
Зорилт 3.4.2. Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн чадавх, орлогыг нэмэгдүүлж, ажлын байрыг 30 хувиар нэмэгдүүлнэ.								
110	ЗДҮАХХАХТ 3.4.2.1 Аялал жуулчлалын үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгч иргэд болон ААН-үүдийн үйл ажиллагаагаа өргөжүүлэх санал санаачлагыг дэмжиж, ногоон санхүүжилт, бусад хөнгөлөлттэй зээлийн хөтөлбөрт хамруулна.	-	хувиар	Ажлын байрыг 10.2 хувиар нэмэгдүүлсэн.	Ажлын байрыг 10 хүртэл хувиар нэмэгдүүлнэ.	Аялал жуулчлалын салбарын эдийн засгийн чадавх орлогыг нэмэгдүүлэх зорилгоор нүхэн жорлонг буулгуулж эко нойл барих арга хэмжээнд ногоон зээл олгох ажлыг Хас банктэй хамтран зохион байгуулсан. Мөн нээлттэй Хэнтий арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа явуулах сонирхолтой иргэн аж ахуй нэгжид бизнес эрхлэх, хөрөнгө оруулалт хийх боломж, давуу талыг танилцуулж ажиллалаа. 2021-2023 онд 2 ААН 175,0 сая төгрөгийн зээл авч үйл ажиллагаагаа өргөжүүлээд байна. Хэрлэн суманд 50-60 хүн хүлээн авах чадалтай, 6 гэр 7 шовгор, ресторан зоогийн газрын 2 байшинтай Элит мандал амралтын газар байгуулагдаж, 20-30 хүн шинээр ажлын байраар хангагдаад байна. Ажлын байр суурь түвшнээс 17,7 хувиар нэмэгдсэн.	100	100
Зорилт 3.4.3. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх ажлын хүрээнд “Мянганы суут хүн Чингис хаан” цогцолборуудын ажлыг /Дадал сум “Чингис хаан”, Биндэр сум “Их Хуралдай”, Батноров сум “Хүлэг Боорчи-Андлалын өргөө”, Норовлин сум “Шихихутаг-Их засаг”, Бэрх тосгон “Монголын далд уурхайн музей, сургалт, судалгаа, аялал жуулчлалын төв”, Дэлгэрхаан сум “Монголын нууц товчоо”/ дуусгаж, дэд бүтцээр холбох ажлыг эхлүүлнэ.								

111	ЗДҮАХХАХТ 3.4.3.1 "Мянганы суут хүн Чингис хаан" цогцолборуудын ажлын үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт тавьж ажиллана.	УТХО-16769.6	Гүйцэтгэлийн хувиар	6 цогцолборын гүйцэтгэлийн дундаж 77%	6 цогцолборын гүйцэтгэлийн дундаж 80%-д хүрсэн байна.	Батноров сумын "Тэнгэрийн андгай хөшөөт цогцолбор", Биндэр сумын "Их Хуралдай" цогцолборын бүтээн байгуулалтын ажил 100% бүрэн дууссан. Норовлин сумын "Шихихутаг-Их засаг" цогцолборын 5 багц ажлуудын дундаж гүйцэтгэл 94%-тай, Дэлгэрхаан сумын "Монголын нууц товчоо" цогцолборын барилгын ажлын гүйцэтгэл 96%-тай үргэлжилж байна. Дадал суманд байгуулж буй "Чингис хаан" аялал жуулчлалын цогцолборын "Мэдээллийн төв"-ийн зураг төсөл боловсруулах ажил 80%-тай хийгдэж байна. Бэрх тосгон дахь Монголын далд уурхайн музей, сургалт мэдээллийн төвийн ажил 98%-тай байна. Нийт 6 цогцолборын гүйцэтгэлийн дундаж 94,6%-д хүрсэн байна.	100	100
Зорилт 3.4.4. Түүхэн аялал жуулчлалыг хөгжүүлэх маршрутын дагуу түр буудаллах цэг, мэдээлэл, үйлчилгээний төвийг байгуулж, эдийн засгийн эргэлтэд оруулна.								
112	ЗДҮАХХАХТ 3.4.4.1 Дэлгэрхаан, Батноров, Өмнөдэлгэр, Норовлин сумдад түр буудаллах цэгүүд барьж, Хэрлэн суманд аялал жуулчлалын мэдээллийн төвтэй байгуулж ашиглалтад оруулна.	-	төсөл хэрэгжсэн эсэх	Жаргалтхаан суманд түр буудаллах цэг байгуулагдсан.	2 суманд түр буудаллах цэг байгуулна.	Дэлгэрхаан, Батноров, Өмнөдэлгэр, Норовлин сумдад түр буудаллах цэг барих зураг төсвийн ажил дуусч хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар бариулах санал гаргаж, нээлттэй танилцуулж ажиллаж байна. Чингис хот дахь Аялал жуулчлалын мэдээллийн төвөөр гадаадын 25, дотоодын 180 гаруй иргэн мэдээлэл авсан байна.	70	30
Зорилт 3.4.5. "Монгол хатад", "Ёохор наадаан", "Чингис фестиваль", "Тогорууны баяр", "Талын түмэн адуу", "Галшар адууны баяр", "Талын тайга нохой" наадам зэрэг эвент арга хэмжээнүүдийн цар хүрээг өргөжүүлэн тогтмол зохион байгуулж, гадаад, дотоодын жуулчдын тоог нэмэгдүүлнэ.								
113	ЗДҮАХХАХТ 3.4.5.1. "Монгол хатадын наадам", "Ёохор наадаан" эвент арга хэмжээг зохион байгуулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	6	арга хэмжээ зохион байгуулсан эсэх	-	2 эвент арга хэмжээг зохион байгуулна.	Батширээт суманд "Ёохор 2023" ардын урлагийн наадам зохион байгуулагдаж Улаанбаатар хот, Өмнөговь, Дорноговь аймгийн 9 хамтлагийн 147 бүжигчид, биет бус өв тээгч нар оролцсон ба тус эвент арга хэмжээг гадаадын 10, дотоодын 2000 гаруй үзэгчид зорьж үзсэн. "Монгол хатадын наадам" 2024 онд зохион байгуулагдахаар шийдвэрлэгдсэн.	100	90

114	ЗДҮАХХАХТ 3.4.5.2 "Тогорууны баяр", "Талын түмэн адуу", "Галшар адууны баяр", "Талын тайга нохой" наадам зэрэг эвент арга хэмжээнүүдийг жил бүр тогтмол зохион байгуулж, жуулчдын тоог нэмэгдүүлнэ.	10.0	арга хэмжээ зохион байгуулагдсан эсэх	2022 онд 4 арга хэмжээг зохион байгуулсан.	4 эвент арга хэмжээг зохион байгуулна.	Биндэр суманд "ТОГОРУУНЫ БАЯР-2023" эвент арга хэмжээ Олон Улсын Тогоруу сангийн удирдах зөвлөл, БОАЖЯам, Зэрлэг ан амьтан судлах хамгаалах төв болон 2 УТХГазар нутгийн хамгаалалтын захиргаа, Архангай, Дорнод, Хэнтий аймгийн 8 сумын 60 гаруй оролцогчид, Америк, Шинэ-Зеланд, Герман, Швед, Орос, Хятад улсын 22 төлөөлөл жуулчид оролцсоноос гадна дотоодын 2500 орчим иргэн үзэж сонирхсон. "Галшар адууны баяр"-ыг зохион байгуулагдаж 4 аймгаас 600 гаруй иргэд оролцлоо. "Талын тайга нохой-2023" арга хэмжээг Хэрлэн суманд зохион байгуулж 3 аймаг 15 сумын 50 гаруй иргэн 100 гаруй тайга нохойны хамт оролцож, 3 төрлийн тэмцээн зохион байгуулж үзэгчдэд сонирхууллаа. Талын Түмэн Адуу өвөл цагийн эвент арга хэмжээ 11 дүгээр сарын 18-19-ний өдрүүдэд зохион байгуулагдаж гадаадын 30 гаруй, дотоодын 3000 гаруй хүн оролцсон. Энэ онд зохион байгуулсан 5 эвент арга хэмжээнүүдэд гадаадын 52, дотоодын 7950-н жуулчин, тур оператор 10 гаруй ХХК оролцож үзэж сонирхсон байна.	100	100
Зорилт 3.4.6. Аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил, цахим орчныг ашиглан дотоод, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.								
115	ЗДҮАХХАХТ 3.4.6.1 Аялал жуулчлалын Олон Улсын үзэсгэлэн /ITM/-д жил бүр оролцож аймаг орон нутгаа сурталчилна.	10.0	арга хэмжээ зохион байгуулагдсан эсэх	ITM-2022 үзэсгэлэнд оролцож давхардсан тоогоор 5000 гаруй иргэнд аймаг орон нутгаа сурталчиллаа.	ITM-2023 үзэсгэлэнд оролцсон байна.	"ITM-2023" Олон Улсын аялал жуулчлалын үзэсгэлэнд Дадал сум болон Чингисийн тоонот, Дангина хатан, Баян гүрэм, Чингисийн гэр бааз, Их удам, Баялаг Биндэряа брэнд бүтээгдэхүүн, Бишрэлт, КН ресторан буудал, Ханбүргэд ресторан буудал гэх мэт 8 жуулчны бааз, 2 зочид буудал оролцож 3000 орчим иргэнд аймаг орон нутгаа сурталчиллаа.	100	100

116	ЗДҮАХХАХТ 3.4.6.2. Аймгийн аялал жуулчлал, түүх соёл, зан заншил, онцлог давуу талуудыг иргэд, олон нийт, жуулчдад сурталчлан таниулах ном, сэтгүүл, зурагт альбом хэвлүүлж, аялал жуулчлалын хөтөч аппликэйшнийг Монгол, Англи хэлээр ашиглалтад оруулна.	25.0	тоогоор	Хэнтий аймагт тавтай морил сэтгүүлийн мэдээллийг шинэчлэн боловсруулж 1000 ширхэг, Аяллын газрын зургийг 1500 ширхгийг шинээр хэвлүүлсэн.	1-ээс доошгүй танилцуулга ном, сэтгүүл хэвлүүлж, хөтөч аппликэйшний хандалтыг нэмэгдүүлсэн байна.	Хэнтий аймгийн 100 жилийн ойд зориулан түүхэн аялал жуулчлалыг сурталчилсан "Хан Хэнтийн түүхэн жимээр" зурагт фото альбом болон "Хан Хэнтий нутагт тавтай морил" QR код бүхий сумдын түүхэн дурсгалт газруудын танилцуулгатай сэтгүүлийг хэвлүүлж иргэд олон нийт, зочид, аялал жуулчлалын салбарын хөрөнгө оруулалт сонирхогчдод түгээсэн. Мөн аймаг орон нутгаа сурталчлах зорилгоор "Khentii guide" гар утасны аппликэйшний бар кодыг үйлчилгээний төв болон тээврийн хэрэгслүүд, зочид буудал, зоогийн газруудад байрлуулсан хандалтын тоо 500 гаруй байна. Талын түмэн адуу эвент арга хэмжээ Монголын албан ёсны олон улсын эвентээр бүртгэгдэж дэлхийн 7 улсын хэл дээр орчуулагдан гадаад улс орнуудад сурталчлагдаж байна.	100	100
Зорилт 3.4.7. Аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг чадваржуулах, үйлчилгээний байгууллагуудын чанар, стандартыг сайжруулах сургалт, зөвлөгөөнийг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан жил бүр зохион байгуулж, зочид буудлуудын зэрэглэлийг 1 шатаар ахиулна.								
117	ЗДҮАХХАХТ 3.4.7.1. Иргэдэд мэргэжил олгох сургалтыг жил бүр зохион байгуулж, 1000 хүртэл хүнийг хамруулна.	-	тоогоор	6 удаагийн сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 500 гаруй зочид буудал, үйлчилгээний салбарын ажилтан, албан хаагчид, иргэдийг хамрууллаа.	200-300 иргэн	Хэнтий аймгийн Дадал сумын Баян-Овоо багийн Соёлын төвд "Нутгийн хөгжилд-эмэгтэйчүүдийн оролцоо" сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж аялагчдад ёсзүйн дүрмийг дагаж мөрдүүлэх шаардлага, хэрэгцээ, газартаа жуулчин, амрагч хүлээн авах боломжтой байршуулах хэрэгслийг бий болгох зэрэг 8 чиглэлээр 3 өдрийн турш сургалт хэлэлцүүлгийг зохион байгуулж давхардсан тоогоор нийт 300 орчим иргэдийг хамруулсан. Мөн Жуулчны баазын эко гэрчилгээжүүлэлт сэдвээр сургалт зохион байгуулж уг 50 гаруй хүн хамрагдсан. Нийт 350 иргэдийг аялал жуулчлалын мэдлэг, мэдээлэл, ур чадвар олгох сургалтад хамруулсан.	100	100

118	ЗДҮАХХАХТ 3.4.7.2. Зочид буудал, жуулчны бааз, рестораны 400-с доошгүй удирдлага, үйлчилгээний ажилтныг сургалтад хамруулж, зочид буудал, жуулчны баазуудын зэрэглэлийг тодорхойлон үнэлгээ хийж ангилан батлагдсан стандартыг хангуулна.	6	ангилал зэрэглэл тодорхойлсон эсэх	Жуулчны баазуудыг стандартын дагуу ангилж, зэрэглэл тогтоох ажил хийгдсэн ба шаардлага хангасан, жилийн турш тогтмол үйл ажиллагаа явуулдаг жуулчны бааз байхгүй байна.	1-ээс доошгүй зочид буудлын зэрэглэлийг ахиулсан байна.	Зочлох үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Хорика институттай хамтран Ханбүргэд, КН зочид буудалтай гэрээ байгуулан тус бүр 3 удаагийн сургалтыг ажлын байран дээр зохион байгуулж, нийт 140 орчим хүнийг хамруулаад байна. Монголын зочид буудлуудын холбооноос зохион байгуулагдсан “Hospitality&tourism international expo 2023” үзэсгэлэнд зочлох үйлчилгээний салбарын 2 ААН-ийг оролцуулж, салбарын 6 ажилтныг чадавхжуулах сургалт, арга хэмжээнд хамруулсан. Мөн аялал жуулчлалын томоохон үзэсгэлэн болох Улаанбаатар экспо-2023 арга хэмжээнд 6 жуулчны бааз, 1 зочид буудлын төлөөлөл оролцсон. 2023 онд аймгийн төвийн "КН"-зочид буудлыг од зэрэглэлийн стандартыг хангуулах зорилгоор Монголын Зочид буудлуудын холбоотой хамтран стандартын үнэлгээг хийлгүүлж хамтран ажиллаж байна. Стандартад өөрчлөлт орж байгаатай холбоотойгоор зэрэглэл тогтоох баталгаажилт түр хойшлогдоод байна.	70	70
Зорилт 3.4.8. Түүх, соёлын өв, байгалийн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газрууд, орон нутгийн онцлог тохируулан аялагч, амрагч, жуулчдыг татах төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн /морин аялал, завь, агнуур, дугуйн, цанын, уулын спорт г.м/-ийг бий болгож, хөгжүүлнэ.								
119	ЗДҮАХХАХТ 3.4.8.1. Жуулчны баазуудыг түшиглэн орон нутгийн онцлог, байгалийн дурсгалт болон өвөрмөц тогтоц бүхий газруудад төрөлжсөн аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг бий болгоно.	-	тоогоор	2 суманд 3 төрөлжсөн аяллын бүтээгдэхүүн бий болсон.	2-оос доошгүй төрөлжсөн аялал жуулчлалын бүтээгдэхүүн бий болгосон байна.	Ивээлт хайрхан жуулчны бааз ан агнуурын, Онон – Ёл бааз Завь, Хэнтий эко бааз Аргал ажиглах, дурандах, Чингисийн өлгий бааз завь, морь, загасчлах зэрэг 5 төрлийн тусгай сонирхлын төрөлжсөн аяллууд бүхий бүтээгдэхүүн үйлчилгээг бий болгож хөгжүүлж байна.	100	100

120	ЗДҮАХХАХТ 3.4.8.2. Хил залгаа аймаг, сумдтай хамтран аяллын маршрут бий болгоно.	-	маршрут бий болсон эсэх	маршрут боловсруулагдсан	Зүүн бүсийн аяллын маршрутыг батлуулж, сурталчилна.	Хил залгаа Дорнод, Сүхбаатар аймгуудыг холбосон аяллын sg40, болон зүүн бүсийн аяллын маршрут гарган аялагчдад сурталчлан ажиллаж байна. Уг аяллын маршрутаар аялахад 3 аймгийн 84 түүхэн дурсгалт газруудаар нийт 4200 километр замаар 15шөнө 1бөдөр аялна. Мөн аймгийн түүхэн дурсгалт газар болон үйлчилгээг сурталчлах зорилгоор жуулчин явуулдаг 25 Тур оператор компанийн 28 хүнд аймгийн түүхэн дурсгалт газрууд болон маршрутыг танилцуулах аяллыг 2023 оны 9 сард зохион байгуулж шинээр аяллын маршрутыг бий болгосон. Уг маршрутыг 3 аймгийн хурал, зөвлөгөөн, чуулганы арга хэмжээнд танилцуулж дотоод, гадаадын жуулчдад түгээх, сурталчлах ажлыг зохион байгуулж, тур оператор компаниудад санал болгоод байна	100	100
Дэд бүтцийн салбар								
Зорилго 3.5. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж, орон сууцны хангамжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэмэгдүүлэн, холбоо, цахилгаан, дулаан хангамжийн чанар хүртээмжийг сайжруулж, агаарын болон авто зам, гүүр ашиглалтыг нэмэгдүүлнэ.								
Зорилт 3.5.1. Аймгийн Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг сайжруулж, орон сууцны хангамжийг төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд нэмэгдүүлэн, холбоо, цахилгаан дулаан хангамжийн чанар хүртээмжийг сайжруулж, агаарын болон авто зам, гүүр ашиглалтыг нэмэгдүүлнэ.								
121	ЗДҮАХХАХТ 3.5.1.1 Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулж батлуулна.	342870	Ерөнхий төлөвлөгөөг боловсруулж, батуулсан эсэх	Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг "Вектор мэл" ХХК-тай ажил гүйцэтгэх гэрээг байгуулан боловсруулж байна.	Ерөнхий төлөвлөгөөг батуулах.	Аймгийн Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг Хэнтий аймгийн ИТХ-ын 2023 оны 7 дугаар сарын 3-ны 21 дүгээр хуралдаанаар хэлэлцүүлэн 02 дугаар тогтоолоор батлуулсан.	100	100
122	ЗДҮАХХАХТ 3.5.1.2 Сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах	-	Ажлын гүйцэтгэлээр		Сумын төлөвлөгөөг батлуулах	2023 онд Жаргалтхаан, Биндэр, Баян-Адарга, Норовлин, Баян-Овоо сумдын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг сумдын ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулж, сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө, тайланг орон нутагт нь хүлээлгэн өгч, цахим системд байршуулсан. Аймгийн хэмжээнд бүх сумд нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөтэй болсон.	100	100

123	ЗДҮАХХАХТ 3.5.1.3. Хэрлэн, Бор-Өндөр, Дадал, Галшар, Батширээт, Норовлин, Биндэр, Өмнөдэлгэр сумдад иргэнд өмчлүүлэх боломжтой газарт газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, байрзүйн зураглал хийх, газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулна.	-	Сумын тоогоор	13 сум, 1 тосгон	3 сум	2023 онд 18 сумын төвийн тэг гортигийг шинэчлэх саналыг сумдаас авч Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд төвийн тэг гортигийг шинэчлэх саналыг тусган Аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулсан.	100	100
124	ЗДҮАХХАХТ 3.5.1.4. Хаягжуулалтын мэдээллийн нэгдсэн системийг бий болгож улсын болон орон нутгийн чанартай авто зам, гудамж талбай, газар нутаг, үл хөдлөх хөрөнгийг хаягжуулах ажлыг зохион байгуулах /Хэрлэн, Батширээт, Норовлин, Галшар, Мөрөн, Дархан, Жаргалтхаан, Баян-Адарга сум, Гурванбаян, Өлзийт тосгон/	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	3 суманд хаягийн тэмдэг суурилуулах ажил хийгдсэн.	Өөрчлөлт, шинэчлэлтийг тухай бүр хийж, хаягийн тэмдэг суурилуулах ажлыг үе шаттайгаар зохион байгуулна.	Мөрөн сумын хаягжуулалтын ажил дуусаж, Дархан сумын ажил үргэлжилж байна.	70	50
125	ЗДҮАХХАХТ 3.5.1.5. Газар зүйн нэрийн тодруулгын ажлыг хийж газар зүйн нэрийн мэдээллийн санг байгуулах, олон нийтэд таниулах ажлыг зохион байгуулах	-	Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувиар	2 сум	Газар зүйн нэрийн тодруулгын ажлыг хийж гүйцэтгэн газар зүйн нэрийн мэдээллийн санг байгуулж, газарзүйн зөв нэршлийг түгээн дэлгэрүүлнэ.	Өмнөдэлгэр, Дадал сумдын газар зүйн нэрийн тодруулалтын ажлын Бэлтгэл үе шатны ажлаар Өмнөдэлгэр, сумын 1418, Дадал сумын 570 нийт 1988 УИХ-ын тогтоолоор батлагдсан газар зүйн нэрийг 1:100000 масштабтай байрзүйн зураг, Газар нутгийн нэрийн зурагтай харьцуулан зураглан хээрийн хэмжилт судалгааг хийж, ажлын явц 85% байна.	70	90

Зорилт 3.5.2. Анх удаа орон сууц худалдан авч байгаа холбогдох шаардлагыг хангасан 300-аас доошгүй иргэдийг хөнгөлөлттэй зээлд хамруулна.

126	ЗДҮАХХАХТ 3.5.2.3. Шаардлага хангасан иргэдийг зээлд хамруулна.	-	Зээлд хамрагдсан иргэдийн тоо	жилд дунджаар 100 иргэнд зээл олгодог	100-аас доошгүй иргэдийг зээлд хамруулж эхэлнэ.	2023 онд аймгийн хэмжээнд нийт 32 иргэнд зээл олгосон. Мөн Хаан банкны Орон нутгийн иргэдийн банктай "Иргэдэд орон сууцны ипотекийн зээл олгоход хамтран ажиллах" гэрээг байгуулж, гэрээний хүрээнд 20 иргэнд шинээр зээл олгохоор шийдвэрлэсэн.	50	70
Зорилт 3.5.3. 120-оос доошгүй айлын түрээсийн орон сууцны барилгын ажлыг эхлүүлнэ.								
127	ЗДҮАХХАХТ 3.5.3.1. ТОСК-той хамтран ажиллах	-	Гүйцэтгэлийн хувь		Барилгын ажлын гүйцэтгэл 50 хувьд хүрсэн байна.	ТОСК-ийн талаас хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар орон сууцны барилга барих ААН-ийн сонгон шалгаруулалтыг зарлаж төслүүдийг хүлээн авсан байна. Орон нутгаас хүргүүлсэн орон сууц барих боломжтой газрын саналын дагуу зураг төслийг шинэчлэх саналыг ТОСК-оос СЯ-д хүргүүлсэн.	70	70
128	ЗДҮАХХАХТ 3.5.3.2. Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд орон сууц барих аж ахуйн нэгжүүдийг дэмжиж ажиллана.	-	Дэмжсэн эсэх		орон сууцны барих санаачлагыг дэмжсэн байна.	Холбогдох газрын зөвшөөрөл, барилгын ажлыг эхлүүлэх зөвшөөрөл гэх мэт төрийн байгууллагын шаардлагатай дэмжлэгийг үзүүлж Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар аймгийн хэмжээнд нийт 644 айлын орон сууцны барилга баригдахаар төлөвлөгдсөнөөс Хэрлэн суманд нийт 439 айлын 13 блок, Баян-Овоо, Батноров, Биндэр сумд, Бэрх тосгонд 88 айлын 4 блок орон сууцны БУА үргэлжилж байна.	100	100
Зорилт 3.5.4. Чингис хотын ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлж, барилга байгууламж, тоног төхөөрөмжийг шинэчлэн өргөтгөх, шинээр худаг гаргах замаар баталгаат ундны усны тоог нэмэгдүүлнэ.								
129	ЗДҮАХХАХТ 3.5.4.1 Эх үүсвэрийн худагт шаардлагатай засвар, шинэчлэл хийж, шинээр эх үүсвэрийн худаг гаргана.	300	Ажлын гүйцэтгэлээр	-	Эх үүсвэрийн шинэ худаг гаргасан байна.	Хэрлэн сумын 2, 4, 5, 7 дугаар ус түгээх байруудыг ухаалаг төхөөрөмжид холбосон. Хэрлэн голын эргийн эх үүсвэр дээр 1 худаг шинээр гаргасан.	100	100

130	ЗДҮАХХАХТ 3.5.4.2. Нөөц усны сан байгуулна.	-	Ажлын гүйцэтгэлээр	-	Нөөц усны сангийн ТЭЗҮ хийгдсэн байна.	2023 онд Чингис хотын ус хангамжийн эх үүсвэрийг нэмэгдүүлэх гидрогеологийн судалгаа болон эх үүсвэрийн 3 шинэ худаг нөөцийн сав байрлуулах, 14км зайнаас хот руу орох инженерийн шугам сүлжээний ажлын зураг төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж гэрээ хийсэн байна. Тус ажлын гидрогеологийн судалгааг хийж дуусгасан ба ажлын зураг төсвийн явц 80 хувьтай үргэлжилж байна.	90	70	
Зорилт 3.5.5. Чингис хотын үерийн байгууламжийг ашиглалтад оруулж, хот доторх ус зайлуулах сувгийг бий болгоно.									
131	ЗДҮАХХАХТ 3.5.5.1. Үерийн байгууламжийг ашиглалтад оруулна.	3481.0	ажлын гүйцэтгэлээр	2022 онд нийт 8660 метр урттай үерийн хамгаалалтын далангийн ажлыг 40 хувь гүйцэтгэж, ажлын явц 60 хувьтай байна.	2023 оны төлөвлөгөөт ажил хийгдэнэ.	Хэрлэн сумын "Үерийн усны хамгаалалтын далан суваг"-ын ажил 6.2 км ус зайлуулах бетон суваг хийгдсэн.	100	100	
132	ЗДҮАХХАХТ 3.5.5.2. Хотын доторх гадаргуугийн ус зайлуулах систем байгуулна.	2000.0	Ажлын гүйцэтгэлээр	Хотын доторхи гадаргуугийн ус зайлуулах системийн зураг төслийн ажил хийгдэж дууссан. Магадлалын шатанд байна.	Хотын доторх гадаргуугийн ус зайлуулах системийн барилгын ажил эхэлнэ.	Аймгийн төвийн авто замын 8,6км ус зайлуулах сувгийн ажлууд бүрэн дууссан.	100	100	
Зорилт 3.5.6. Шилэн кабелийн сүлжээг өргөтгөж, хурдыг сайжруулна.									
133	ЗДҮАХХАХТ 3.5.6.3. Чингис хотын гэр хороололд шилэн кабель татна.	70.0	Ажлын гүйцэтгэлээр	Үүрэн холбооны Unitel Group Чингис хотын 60%-ийг шилэн кабельд холбосон.	Чингис хотын 2 багийн гэр хорооллын өрхийг шилэн кабельд холбоно	2023 онд Unitel Group нь чингис хотын 2,3,4-р багт өргөтгөл хийж ажилласан. Мөн Үүрэн холбооны G mobile ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан шаардлагатай цэгт интернэтийн үйлчилгээг сайжруулах ажлыг хийж байна.	100	100	
Зорилт 3.5.7. Дулааны станцыг ашиглалтад оруулна.									
134	ЗДҮАХХАХТ 3.5.7.1. Дулааны станцыг ашиглалтад оруулна.		Ажлын гүйцэтгэлээр	БУА хийгдэж байна	БУА үргэлжилнэ.	Дулааны станцын барилгын ажлыг үндсэн гүйцэтгэгч БНСУ-ын "Бьюксан инженеринг" компани, туслан гүйцэтгэгчээр "Хасу мегаватт" компани гүйцэтгэж, ажлын явц 60 хувьтай үргэлжилж байна. Тус ажилд 2 удаагийн хяналт хэрэгжүүлж, 1 удаагийн трассын хамтарсан үзлэг хийж, тухай бүр явцын мэдээ, тайлан гаргаж ажиллалаа.	100	100	

Зорилт 3.5.9. Шаардлагатай багийн төвүүд болон шинээр олгогдсон өмчлөлийн газруудад 04 кв-н цахилгааны шугам тавина.								
135	ЗДҮАХХАХТ 3.5.9.1 Шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангана.	150.0	ЦЭХ-ээр хангагдсан нэгж талбарын тоо	3200 нэгж талбар ЦЭХ-ээр хангагдаагүй байна	Шинэ суурьшлын бүсийг үе шаттай ЦЭХ-ээр хангана.	ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 3 сум, Улсын төсвийн 650 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 6 сумын шинэ суурьшлын бүсийн хэрэглэгчдийг эрчим хүчинд холбох ажил үргэлжилж байна. Дархан, Өмнөдэлгэр сумдад шинээр 2 дэд станц байгуулагдсан. Улсын төвийн хөрөнгө оруулалтаар Хэнтий аймгийн Батноров, Дадал, Норовлин, Баян-Овоо, Баянхутаг, Өмнөдэлгэр, Батширээт, Хэрлэн сумдад шинэ суурьшлын бүсийг цахилгаан эрчим хүчээр хангасан.	100	100
Зорилт 3.5.10. Хэрлэн гол болон бусад голуудад шаардлагатай гүүрийг шинээр барьж, сэргээн засварлана.								
136	ЗДҮАХХАХТ 3.5.10.1 Ашиглалтын шаардлага хангахгүй гүүрийг үе шаттай засварлана.	100.0	Ажлын гүйцэтгэлээр	Батширээт сумын Баян гол, Эгийн голын модон гүүрийг засварлаж, Амгалантын голд шинээр модон гүүр барьсан.	Сумдын гүүрүүдийг засварласан байна.	2023 онд засварлах шаардлагатай байсан модон гүүрнүүдээс Дадал суманд 5, Батширээт суманд 1, Баян-Адарга суманд 2, Биндэр суманд 1, Өмнөдэлгэр суманд 1 гүүрний ажил эхэлсэн нийтдээ 10 модон гүүрний засварыг хийж гүйцэтгэсэн.	100	100
137	ЗДҮАХХАХТ 3.5.10.2 Хэрлэн гол болон бусад голуудад шинээр гүүр барина.		Ажлын гүйцэтгэлээр	Батширээт сумын Онон голын 209 метр төмөр бетон гүүрийний барилгын ажлыг бүрэн дуусгаж ашиглалтад хүлээлгэж өгсөн.	Хэрлэн голд шинээр баригдах гүүрийн ажил эхэлнэ. Бархын голын төмөр бетон гүүрийн ажил дуусч ашиглалтад орно.	Батширээт сумын Бархын голын 121м гүүр ашиглалтад орсон, "Чингис хотыг тойрон гарах 14,42 км авто зам, шинээр барих Хэрлэн голын 265,72у/м төмөр бетон гүүрийн зураг төсөл хийгдэж дууссан. Улсын төсвийн 2024 оны төлөвлөлтөд санал оруулж батлагдаад хэрэгжиж эхлэхэд бэлэн болоод байна.	70	90
Зорилт 3.5.11. Хот хоорондын болон орон нутгийн нийтийн тээвэр, шуудан үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна.								
138	ЗДҮАХХАХТ 3.5.11.2 Орон нутгийн нийтийн тээврийн үйлчилгээний хүрээг өргөтгөнө.		Ажлын гүйцэтгэлээр	-	2-оос доошгүй сум руу нийтийн тээврийг боловсронгуй болгож жигдрүүлнэ.	2023 оны Эрдэм Транс ХХК нь Улаанбаатар- Өндөрхаан-Батноров сум-Норовлин сум-До.Баян-Уул чиглэлд 2 сумыг дамжин нийтийн тээврийн үйлчилгээг үзүүлж байна.	100	50

139	3.5.12.4. Ерөнхий зориулалтын нислэг үйлдэнэ.	-	-	Ерөнхий зориулалтын нислэг үйлдэнэ.	Өндөрхаан нисэх буудлын 104 га талбайд аэрдромын зурвасын ажил 100% дууссан, барилга угсралтын ажил 70 хувь нийт ажил 85%, Дэлүүн Болдог нисэх буудлын барилгын явц 70 хувьтай ажил үргэлжилж байна. Орон нутагт захиалгат нислэг үйлдэх авиа компаниудтай уулзалт хийж тусгай, захиалгат нислэг үйлдэх боломжийн талаар судалж, холбогдох аж ахуй нэгжүүд рүү санал хүргүүлэн нисэх буудал ашиглалтад орохоор захиалгын нислэг үйлдэх санамж бичиг байгуулав.	30	30	
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛ								
Цахим Хэнтий төрийн шуурхай үйлчилгээ								
Зорилго 4.1 Төрийн байгууллагад дотоод удирдлагын нэгдсэн систем www.e-mongolia.mn болон иргэн хуулийн этгээдэд төрийн үйлчилгээг шуурхай чирэгдэлгүй хүргэх e-mongolia системийг үе шаттайгаар нэвтрүүлж, ил тод байдлыг нэмэгдүүлнэ.								
Зорилт 4.1.2 Дотоод удирдлагын нэгдсэн систем www.erp.e-mongolia.mn-ийг нэвтрүүлсэн төрийн байгууллагуудын албан хаагчдын хэрэглээг тогтмолжуулах хяналт тавих ажлыг зохион байгуулна.								
140	ЗДҮАХХАХТ 4.1.2.1 www.erp.e-mongolia.mn-ийг нэвтрүүлэх багийн гишүүдээр дамжуулан хуваарилагдсан байгууллагуудад сар, улирал тутам цахимаар болон биечлэн хяналт тавьж, хэрэглээг тогтмолжуулна.		Системийг хэрэглэж хэвшсэн албан хаагчдын тоо	187 байгууллагын 1129 албан хаагчдын ERP системийг өдөр тутмын хэрэглээндээ хэвийн ашиглаж хэвшсэн	187 байгууллагын 1129 албан хаагчид 100 хувь нь хэрэглэж хэвшсэн байна.	erp.e-mongolia.mn системийн хэрэглээнд ажлын хэсэг 1 удаа биечлэн 35 удаа цахимаар хяналт тавихад 1597 албан хаагч өдөр тутмын үйл ажиллагаандаа 100 хувь ашиглаж хэвшсэн байна.	100	100
Зорилт 4.1.3 e-mongolia.mn системийн -ийг эвтрүүлсэн төрийн байгууллагуудын албан хаагчдын хэрэглээг тогтмолжуулах хяналт тавих ажлыг зохион байгуулна.								
141	ЗДҮАХХАХТ 4.1.3.1 Иргэдэд биечлэн үйлчилгээ үзүүлж байгаа байгууллагын албан хаагчдад тулгуурлан сурталчилан таниулах ажлыг зохион байгуулна.	10 сая	Төрийн үйлчилгээг биечлэн авсан иргэдийн тоо		Төрийн үйлчилгээг биечлэн авсан иргэдийн тоог 15 хувиар бууруулна.	Төрийн үйлчилгээг биечлэн авсан иргэдийн тоог 16 хувиар бууруулж, 21 аймгаас E-mongolia хэрэглэсэн иргэдийн тоогоор 2023 оны байдлаар 5 дугаарт эрэмбэлэгдсэн.	90	100
Зорилт 4.1.4 Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа 187 төрийн байгууллагын 4500 төрийн албан хаагчид болон 120 чиглүүлэгч 791 аравт, хэсгийн ахлагч нарт e-mongolia системийг танилцуулах сургалт зохион байгуулж, ашиглаж хэвшүүлэх ажлыг зохион байгуулна.								

142	ЗДҮАХХАХТ 4.1.4.1 Жилд 2 удаа сургалт зохион байгуулж, ашиглаж хэвшүүлэх нөлөөллийн ажлуудыг зохион байгуулна.		Сургалт зохион байгуулсан тоо		Сургалт зохион байгуулсан тоо	2023 онд E-mongolia системийн ашиглалтын талаарх танилцуулга сургалтыг 18 сумын 88 багт аймгийн удирдлагууд ажиллахад болон сумын е хөтөч хариуцсан албан хаагчид багийн иргэдийн нийтийн хурал дээр тус тус аймгийн хэмжээнд баг бүрт 2 удаагийн сургалт зохион байгуулж 14000 гаруй иргэнийг хамруулсан.	90	100
Зорилт 4.1.5. Хэнтий.мн сайтад 18 сумын төрийн байгууллагуудыг холбож үйл ажиллагаа, хүний нөөц, төсөв санхүү, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангана.								
143	ЗДҮАХХАХТ 4.1.5.1. Хэнтий.мн сайтад 18 сумыг холбон админы эрх үүсгэн, мэдээллийн ил тод байдлыг хангах үүрэг бүхий албан тушаалтныг томилгоожуулж, ажлын чиг үүргийг тодорхойлсон журам батална.		Хувь	Шударга байдлын үнэлгээний ил тод байдлын үнэлгээ 3 хувь	Шударга байдлын үнэлгээний ил тод байдлын үнэлгээ 3,5 хувьд хүрсэн байна.	2023 оны байдлаар www.khentii.mn сайт болон 18 сум, 4 тосгонд 1 стандарт бүхий бүрэн хэмжээний веб сайтуудыг ашиглалтад оруулж Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан мэдээллүүдийг тавих үүрэг бүхий албан тушаалтнуудыг томилгоожуулж, ажлын чиг үүргийг журамласнаар ил тод байдлын үнэлгээ 3 хувьд хүрсэн. Мөн Цахим хөгжил харилцаа холбооны яамны зөвлөмж болон албан бичгийн дагуу мэдээллийн ил тод байдлыг нийтэд хүргэх khenti.mn сайтад ил бод байдлыг хангах хэсэгт холбогдох хуулийн заалт ангилал тус бүрээр мэдээллүүдийг байршуулан мөн тус хуультай холбоотой бусад мэдээллүүдэд тохирох цэсүүдийг үүсгэн тухай бүрд нийтэд хүртээн shilen.gov.mn сайтад 100% үнэлгээтэй ажиллаж байна.	90	90
Зорилт 4.1.6. Төвийн болон орон нутгийн хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулж нутгийн захиргааны байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг хангана.								
144	ЗДҮАХХАХТ 4.1.6.1. Судалгаанд үндэслэн үндэсний тэргүүлэх хэвлэл мэдээллийн байгууллагууд, орон нутгийн хэвлэл мэдээллийн хэрэгслүүдтэй хамтран ажиллах гэрээ байгуулахаас гадна цахим орчинд аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, нутгийн захиргааны	70 сая	Мэдээлэл авсан иргэдийн хувь	нийт хүн амын 70 хувь нь мэдээлэл авч байна.	Аймгийн нийт хүн амын 75 хувьд мэдээлэл хүрсэн байна.	Khentii.mn сайт, Хэнтий аймгийн ЗДТГ, Хэнтий-100, Нээлттэй Хэнтий аймаг пэйж хөтлөн давхардсан тоогоор 10000 орчим мэдээ мэдээлэл иргэдэд хүргэсэн. 9 хэвлэл мэдээллийн байгууллагатай хамтран ажиллаж байна. Эдгээр пэйжүүдийн хандалтаар нь дүгнэвэл хүн амын 75 хувьд мэдээлэл хүргэсэн. Контент-60, Мэдээ мэдээлэл, 10,000, постер-200, шторк-30 нийт 10,200 гаруй мэдээ мэдээлэл тв болон цахим орчинд түгээсэн.	100	100

	байгууллагын ил тод байдлыг олон нийтэд сурталчлах ажлыг жил бүр төлөвлөн хэрэгжилтийг хангаж ажиллана.								
Зорилт 4.1.7. Иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж төрийн байгууллагын ил тод байдлыг хангах "Иргэдийн оролцоот-Хэтийн Хэнтэй" арга хэмжээг хэрэгжүүлнэ.									
145	ЗДҮАХХАХТ 4.1.7.1. "Иргэдийн оролцоот хэтийн Хэнтэй" арга хэмжээний төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангаж ажиллана.	100 сая	Иргэдийн оролцооны хувь	2022 онд иргэдийн оролцоо 75 хувь	Иргэдийн оролцоог 85 хувьд хүргэнэ.	30 арга хэмжээ бүхий төлөвлөгөө боловсруулан батлуулсан бөгөөд 21 арга хэмжээг хэрэгжүүлж ажилласан. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбогдуулан 9 арга хэмжээг зохион байгуулах боломжгүй болсон. Иргэдийн оролцооны хувь 92 хувьд хүрсэн.	100	100	
Мэргэшсэн, хариуцлагатай төрийн алба									
Зорилго 4.2. Авлигатай тэмцэх арга хэмжээг хэрэгжүүлэн, төрийн үйлчилгээний чанар, төрийн албан хаагчийн мэдлэг, чадварыг сайжруулан, сахилга, хариуцлагыг чангатгана.									
Зорилт 4.2.1. Авилгатэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймаг орон нутгийн онцлогт тохируулан жил бүр боловсруулан "Эрх бүхий албан хаагчдын баг"-аар дамжуулан хэрэгжилтийг зохион байгуулна.									
146	ЗДҮАХХАХТ 4.2.1.1 Аймагт хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр боловсруулж "Эрх бүхий албан тушаалтны баг"-аар дамжуулан хэрэгжилтийг зохион байгуулна.	5 сая	хувь	90	90-ээс дээш хувьтай байна.	Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг аймагт хэрэгжүүлэх 17 заалттай төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг 100% хангаж ажилласан. Шударга байдлын үнэлгээ улсын дунджаас тогтмол дээгүүр үнэлэгдэж байна.	100	100	
Зорилт 4.2.3. Сумдын Засаг даргын Тамгын газар, Хот, тосгоны захирагчийн ажлын алба, Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Архивын тасаг зэрэг иргэдэд төрийн үйлчилгээг шууд хүргэдэг байгууллагуудын албан хаагч нарын үйл ажиллагааг иргэн үнэлдэг төхөөрөмж, дуу, дүрсний хяналтын системийг нэвтрүүлнэ.									
147	ЗДҮАХХАХТ 4.2.3.1 Сумдын Засаг даргын Тамгын газар, Хот, тосгоны захирагчийн ажлын алба үйлчилгээний нэгдсэн төвтэй болгох ажлыг зохион байгуулж нэгдсэн төвийн албан хаагчдын үйл	ОНТ	Нэвтрүүлсэн сум тосгоны тоо	5 сум 1 тосгон нэвтрүүлсэн.	8 сум хяналтын систем нэвтрүүлсэн байна.	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн даатгалын хэлтэс, Татварын хэлтэс, Хөдөлмөр халамж үйлчилгээний газар, аймгийн Нэгдсэн эмнэлэг, Архивын тасаг, Авто тээврийн төв болон 17 сум 2 тосгонд нэвтрүүлсэн. Хяналт тавин ажиллагаа хангуулахаар зөвлөгөө, зөвлөмж өгч ажиллаж байна.	100	100	

	ажиллагааг иргэн үнэлдэг төхөөрөмж дуу дүрсний хяналтын системийг нэвтрүүлнэ.							
148	ЗДҮАХХАХТ 4.2.3.3 Хяналтын системийн хэрэгжилтийг хангах хяналт тавих журмыг баталж хэрэгжилтийг ханган ажиллана.	ОНТ	үнэлгээний оноо		Төрийн албан хаагчдын харилцаа хандлага, үйл ажиллагааны дундаж үнэлгээ 4 байна.	Төрийн албан хаагчдын харилцаа хандлага, үйл ажиллагааны дундаж үнэлгээ 4 хувьтай байна.	100	100
Зорилт 4.2.4. Төрийн Улс төрийн, төрийн захиргааны, төрийн үйлчилгээний албаны удирдах болон гүйцэтгэх албан хаагч нартай хариуцлагын гэрээ байгуулж төрийн албан хаагчийн хяналтын хуудсыг нэвтрүүлж сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн мэдээллийг олон нийтэд улирал тутам мэдээлнэ.								
149	ЗДҮАХХАХТ 4.2.4.2 Хариуцлагын гэрээний хэрэгжилтийг хангах төрийн албан хаагчийн хяналтын хуудсыг хэрэглэх сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагчийн мэдээллийг олон нийтэд мэдээлэх журмыг баталж хэрэгжилтийг ханган ажиллана.	-	гомдлын тоо	2022 онд төрийн албан хаагчдын сахилга хариуцлагатай холбоотой ирсэн гомдлын тоо 8	төрийн албан хаагчдын сахилга хариуцлагатай холбоотой ирсэн гомдлын тоо өмнөх оноос нэмэгдэхгүй байна.	Төрийн улс төрийн, захиргааны, үйлчилгээний 58 байгууллагын дарга нартай хариуцлагын гэрээг байгуулж, хяналтын хуудас хэрэглэх журмыг батлан, нийт 5258 төрийн албан хаагчид хяналтын хуудас хэрэглэж байна. Сахилгын шийтгэл хүлээсэн албан хаагчдын мэдээллийг цахим хуудсанд тухай бүрт нээлттэй байршуулан, мэдээллийн ил тод байдлыг ханган ажилласан. Хариуцлагын гэрээ болон хяналтын хуудсыг хэрэглэх журмын хэрэгжилтийг хангаснаар аймгийн хэмжээнд 3 гомдол, 6 сахилгын шийтгэл хүлээсэн төрийн албан хаагч байна. Гомдлын тоо буурсан.	100	100
Зорилт 4.2.5. Төрийн албан хаагчдын хэрэгцээ, шаардлагад үндэслэн “Танхимын болон цахим сургалт”-ын нэгдсэн арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж тухай бүр түвшинг тогтооно.								
150	ЗДҮАХХАХТ 4.2.5.1 Танхимын болон цахим сургалтын хөтөлбөрийг жил бүр батлан хэрэгжилтийг ханган ажиллаж төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчдын түвшинг жилд нэг удаа тогтоох ажлыг зохион байгуулна.	10 сая	Хувь	төрийн албан хаагчийн түвшин тогтоох шалгалт аймгийн дундаж 75 хувь	төрийн албан хаагчийн түвшин 80 хувь	“Танхимын болон цахим сургалт”-ын төлөвлөгөөг батлан, 2023 онд 15 удаагийн цахим, 4 удаагийн танхимын сургалтад 15500, 120 гаруй байгууллагын төрийн захиргаа болон үйлчилгээний албан хаагчид хамрагдсан. Төрийн албан хаагчдын түвшин тогтоох шалгалтыг хагас, бүтэн жилээр авч, дундаж үнэлгээ 78%-тай байна.	95	90

Зорилт 4.2.6. ОХУ болон БНХАУ-ын хамтын ажиллагаатай муж, хотууд, гуравдагч орны боловсрол, соёл урлаг, спорт, хөдөө аж ахуй, худалдаа, байгаль орчин, аялал жуулчлал зэрэг салбарт төрийн болон аж ахуй нэгж байгууллага, бизнес эрхлэгчдийг хамтран ажиллахад дэмжлэг үзүүлж, туршлага судлах боломжоор хангана.

151	ЗДҮАХХАХТ 4.2.6.1 ОХУ болон БНХАУ-ын хамтын ажиллагаатай муж, хотуудын нийгэм эдийн засгийн болон хамтран ажиллах боломжтой салбарын мэдээллийг гаргаж сумдын ЗДТГ, төрийн байгууллага, аж ахуй нэгж, бизнес эрхлэгчдэд хүргүүлж хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлнэ.	-	хөрөнгө оруулалтын хэмжээ /мөнгөн дүн/	2021 онд ОХУ болон БНХАУ-ын хамтын ажиллагаатай муж, хотоос татсан хөрөнгө оруулалт, бусад орлого 36.5 сая төгрөг	ОХУ болон БНХАУ-ын хамтын ажиллагаатай муж, хотоос татсан хөрөнгө оруулалт, бусад орлого 100 сая төгрөг	БНХАУ-ын Жянсу мужийн Уши хотоос Аялал жуулчлалын цогцолбор барихад дэмжлэг үзүүлэхээр тохиролцсон. Сумын Орлогч, багийн дарга нар БНХАУ-ын Жинин, Хөххоттой танилцаж туршлага судалсан.	90	90
152	ЗДҮАХХАХТ 4.2.6.2. Гуравдагч орны муж, хотуудыг судлан хамтын ажиллагааг эхлүүлэх санал тавьж хамтран ажиллана.	-	хөрөнгө оруулалтын хэмжээ /мөнгөн дүн/	2021 онд Гуравдагч орноос татсан хөрөнгө оруулалт 3.1 тэрбум төгрөг	Гуравдагч орноос татсан хөрөнгө оруулалт 400 сая төгрөг	Монгол Улсын Хэнтий аймаг, Бүгд Найрамдах Киргиз Улсын Чуй муж хоорондын харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурсан. Монгол Улсын Хэнтий аймаг, Бүгд Найрамдах Солонгос Улсын (БНСУ) Данжин хот хоорондын улирлын чанартай ажилтан ажиллуулах хамтын ажиллагааны хэлэлцээр байгуулсан. Гуравдагч орон болох Кувейт Улсын Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтын санаас Өндөрхаан нисэх буудлын барилга хөөрч буух нисэх зурвасын барилгын ажилд 990 сая төгрөг, Япон улсын ЗГ-аас "Өвсний үндэс-Хүний аюулгүй байдлыг хангах буцалтгүй тусламж"-д 417 сая төгрөгийн хөрөнгө оруулсан.	100	100
Амар тайван, орон нутгийн хамгаалалт								
Зорилго 4.3. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг төр хувийн хэвшлийн түншлэлд тулгуурлан хэрэгжүүлж нийт гэмт хэргийг 5 хувь, иргэдийн өмчийн эсрэг хулгайн гэмт хэргийг 15 хувиар бууруулан, гамшигтай тэмцэх чадавхыг нэмэгдүүлж, орон нутгийн хамгаалалтыг сайжруулна.								
Зорилго 4.3.1. Аймгийн хэмжээнд дэвшилтэт технологи бүхий хяналтын камерыг нэмэгдүүлэн, төв магистрал зам дагуу тээврийн хэрэгслийн бүртгэлжилт хурдны дундаж тодорхойлох хяналтын камер байрлуулан нэгдсэн системд холбон засвар үйлчилгээг тогтмолжуулна.								
153	ЗДҮАХХАХТ 4.3.1.3 Чингис хотын хэмжээнд камерын сэргээн засвар, арчилгааг тогтмолжуулах.	5 сая	Засвар үйлчилгээ хийсэн камерын тоо	Чингис хотын 139 камер	Тухайн жилд 139 камерт засвар үйлчилгээг хийсэн байна.	2023 онд Авид хайрхан ХХК-тай гэрээ байгуулан нийт 139 камерт засвар үйлчилгээ хийлгэж, мөн аж ахуй нэгжийн хяналтын камерыг нэгдсэн сүлжээнд холбох ажлыг 5 сая төгрөгөөр гүйцэтгэсэн.	100	100

Зорилт 4.3.2. Бүх нийтийн эрх зүйн боловсролын хүрээнд иргэд, аж ахуйн нэгж байгууллага бүрт хүрч холбогдох хууль тогтоомжийг сурталчилах, хүний эрх, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг төрийн бус байгууллагатай хамтарч зохион байгуулна.								
154	ЗДҮАХХАХТ 4.3.2.1 Бүх нийтийн эрх зүйн боловсролын хүрээнд холбогдох хууль тогтоомжийг сурталчилах, хүний эрх, хууль эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлэх сургалтыг төлөвлөгөөний дагуу жил бүр зохион байгуулна.	20 сая	Сургалтад хамрагдсан иргэн, аж ахуйн нэгжийн тоо	-	Жилд 10 мянган иргэн, аж ахуйн нэгж, төрийн албан хаагчдад хууль тогтоомжийг сурталчлах сургалтыг зохион байгуулна.	Бүх нийтийн эрх зүйн боловсролын төлөвлөгөөний дагуу иргэд, аж ахуй нэгж байгууллага, төрийн албан хаагчдад танхимаар 26, цахимаар 9 удаагийн сургалтыг зохион байгуулж нийт давхардсан тоогоор 12900 төрийн албан хаагч болон иргэний эрх зүйн мэдлэгийг нэмэгдүүлээд байна.	100	100
Зорилт 4.3.3. Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг, хүрээлэн байгаа орчны эсрэг, авто тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журам зөрчих, хүүхдийн эсрэг, цахим мэдээллийн аюулгүй байдлын эсрэг, соёлын өвийн эсрэг, хүн худалдаалах "Гэмт хэргүүдийг таслан зогсоох, илрүүлэх" нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна.								
155	ЗДҮАХХАХТ 4.3.3.1 Нэгдсэн арга хэмжээг жилд зохион байгуулна.	12 сая	Гэмт хэргийн буурсан хувь	-	4-өөс доошгүй удаа Гэмт хэрэг 1.25 хувь буурсан байна.	Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр энэ оны жилийн эцсийн байдлаар 29 нэгдсэн болон тусгай арга хэмжээг зохион байгуулсан байна. Арга хэмжээний талаар Хэнтий аймаг дахь цагдаагийн газар цахим хуудаст 359 удаа мэдээлэл байршуулсан. Энэ оны 12 дугаар сарын байдлаар 669 гэмт хэрэг бүртгэгдэж мөн оны өмнөх үетэй харьцуулахад 5.1 хувиар буурсан байна. /2022 оны 11 сарын байдлаар 630 гэмт хэрэг, 2022 оны жилийн эцсийн байдлаар 705 гэмт хэрэг бүртгэгдсэн/	100	100
Зорилт 4.3.4. Төв суурин газрын ЕБ-н сургуулийн орчин болон хүүхэд олноор зорчих хэсгийг гарц, гэрлэн дохио, хурд сааруулагч, тэмдэг, тэмдэглэгээтэй болгоно.								
156	ЗДҮАХХАХТ 4.3.4.1. Чингис хотын ЕБ-ын сургуулиудын замын зорчих хэсгийг гарц, гэрлэн дохио, хурд сааруулагч, тэмдэг, тэмдэглэгээтэй болгоно.	20 сая	Хурд сааруулагч, тэмдэг, тэмдэглэгээний тоо	-	ЕБ-ын 3 дүгээр сургуулийн орчим хийгдсэн байна.	Хэрлэн сумын 3, 4 дүгээр сургуулийн дундах уулзварт тэмдэг тэмдэглэгээ болон гэрлэн дохиотой болсон. Мөн 5 дугаар сургууль болон 10 дугаар цэцэрлэгийн урд талд явган хүний гарц, гэрлэн дохио, хэвтээ тэмдэглэгээг бүрэн хийж гүйцэтгэсэн.	100	100
Зорилт 4.1.5. Хууль сахиулах байгууллагуудын болон, хил хамгаалалтад туслах хүчний зөвлөл, терроризмтой тэмцэх зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.								

157	ЗДҮАХХАХТ 4.3.5.2.Хилийн шугамын дагуу мөр хянах болон түймрээс урьдчилан сэргийлэх шороон зурвасыг сэргээх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлнэ.	3 сая	Шороон зурвасын хэмжээ	137 км шороон зурвасыг татсан	43 км шороон зурвасыг сэргээнэ.	Аймгийн ЗД-ын 2023 оны А/558 дугаар захирамжаар 3 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж, хилийн шугамын дагуу гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх 43 км шороон зурвас сэргээсэн.	100	100
158	ЗДҮАХХАХТ 4.3.5.4.Терроризмтой тэмцэх зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх.	3 сая	Сургалтанд хамрагдсан хүний тоо		100 хүнийг сургалтанд хамруулсан байх.	Аймгийн Засаг даргын 2023 оны А/295 дугаар захирамж болон А/560 дугаар захирамжаар терроризмтой тэмцэх зөвлөлийн Хэнтий аймаг дахь салбар зөвлөлийн үйл ажиллагаанд 7 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна.	100	100
159	ЗДҮАХХАХТ 4.3.5.7.Шүүхийн шинжилгээний албаны үйл ажиллагаанд шаардлагатай байгаа тоног төхөөрөмжөөр хангах.	2.5 сая	тоног төхөөрөмжөөр хангасан эсэх	-	металл хайгч	Аймгийн Засаг даргын 2023 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн өдрийн А/575 дугаар захирамжаар Шүүхийн шинжилгээний хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж авахад зориулж 9 сая төгрөгийн дэмжлэг үзүүлж дрон, метал хайгч төхөөрөмж авсан.	100	100
160	ЗДҮАХХАХТ 4.3.5.8.Төрийн архивыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж мэдээллийн эргэлтийн санг нэмэгдүүлэх.	15 сая	тоног төхөөрөмжөөр хангасан эсэх	-	Хурдан уншигч А3 сканер	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Архивын цахим санг нэмэгдүүлэх зорилгоор архивын тасагт 19.7 сая төгрөгийн 3 үйлдэлт хэвлэгч машин олгоод байна.	100	100
161	ЗДҮАХХАХТ 4.3.5.10 Улсын бүртгэлийн цогц үйлчилгээг сумдад хүргэхэд дэмжлэг үзүүлнэ	2 сая	Тоон үзүүлэлт	-	16 суманд эд хөрөнгийн бүртгэлийг хийсэн байна.	Аймгийн Засаг даргын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/294 дүгээр захирамжаар 3 сая төгрөгийг шийдвэрлэн Улсын бүртгэлийн хэлтэст дэмжлэг үзүүлсний хүрээнд "Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн цогц үйлчилгээ-нээлттэй газрын харилцаа орон нутаг" өдөрлөгийг тус хэлтэс нь ГХБХБГазартай хамтран 18 сум 4 тосгонд газрын харилцаа улсын бүртгэлийн чиглэлээр үзүүлж буй ажил, үйлчилгээг сурталчилж, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг 537 иргэнд үзүүлж нийт давхардсан тоогоор	100	100

						1564 иргэнд улсын бүртгэлийн талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн байна		
Зорилт 4.3.7. Мал сүргийг халдлагаас хамгаалах тусгай дугаарыг бий болгож, алдуул болон хулгайд алдагдсан малыг бүртгэлжүүлэх санг аймаг, сумын хэмжээнд бий болгоно.								
162	ЗДҮАХХАХТ 4.3.7.1. 18 сумын малын гарал үүслийн гэрчилгээ олгож байгаа газруудад тусгай дугаарын утсыг холбоно.	1 сая	Тоон үзүүлэлт	-	6 сум малын мэдээллийн сантай болсон байна.	Цагдаагийн газрын Эрүүгийн цагдаагийн тасгийн Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тасагт мал эмнэлгийн гэрчилгээ олголтод хяналт тавих зорилгоор нийт 18 сумын хэсгийн төлөөлөгч, мал эмнэлгийн улсын байцаагч нар нэгдсэн цахим мэдээллийн сантай болж мэдээллийг оруулж хэвшээд байна.	100	100
Зорилт 4.3.8. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Эзэнтэй мал” арга хэмжээг хэрэгжүүлнэ.								
163	ЗДҮАХХАХТ 4.3.8.1. “Эзэнтэй мал” арга хэмжээний төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангаж ажиллана.	3 сая	Хулгайн гэмт хэрэг буурсан үзүүлэлт	3 жилийн дунджаар 178 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.	арга хэмжээний төлөвлөгөө 100 хувь хэрэгжсэн байна.	Аймгийн ГХУСАЗСЗ-өөс “Эзэнтэй мал” арга хэмжээний төлөвлөгөө батлан 100 хувь хэрэгжүүлсний хүрээнд мал хулгайлах гэмт хэрэг өмнөх онтой харьцуулахад 23.7 хувиар буурсан дүнтэй байна.	100	100
Зорилт 4.3.9. Өмчийн эсрэг хулгайлах гэмт хэргийг таслан зогсоох шинэ, санал, санаачилгыг дэмжиж, “Хяналт шалгалт”-ын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулна.								
164	ЗДҮАХХАХТ 4.3.9.1 “Хяналт шалгалт”-ын арга хэмжээний төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангаж ажиллана.	10 сая	Хулгайн гэмт хэрэг буурсан үзүүлэлт	3 жилийн дунджаар 389 гэмт хэрэг бүртгэгдсэн байна.	Хулгайн гэмт хэрэг дунджаас 4 хувь буурсан байна.	Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд Цагдаагийн газарт “Хяналт шалгалт” урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээг зохион байгуулахад шаардлагатай 10 сая төгрөгийн дэмжлэг үзүүлээд байна. Өмчийн эсрэг гэмт хэрэг өмнөх оны энэ үетэй харьцуулахад 0.2 хувиар өссөн дүнтэй байна.	100	70
Зорилт 4.3.10. “Архидалтгүй хэтийн Хэнтий” арга хэмжээг зохион байгуулна.								
165	ЗДҮАХХАХТ 4.3.10.1 “Архидалтгүй хэтийн Хэнтий” арга хэмжээний төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангаж ажиллана.	10 сая	Тоон үзүүлэлт	50	30 хувь буюу 15 хүнийг эмийн болон албадан эмчилгээнд хамруулж, 266 иргэнд урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааг зохион байгуулна.	Архидалтгүй хэтийн Хэнтий арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд “Хэрлэнгийн цэнхэр алс” ТББ, “Өндөрхаан Оршихуй” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллан хорт зуршлаасаа өөрийн хүсэлтээр ангижрах хүсэлт гаргасан 24 хүнийг эмийн эмчилгээнд, 1320 иргэнийг сургалтад хамруулсан байна.	100	100
Зорилт 4.3.11. Сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн, команд штабын сургууль, удирдах ажилтны сургалт, ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх үзлэгийг жил бүр зохион байгуулж гамшгаас хамгаалах төрийн үйлчилгээг шуурхай хүргэнэ.								

166	ЗДҮАХХАХТ 4.3.11.1 Сумдад команд штаб, гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль зохион байгуулна.	28 сая	Зохион байгуулсан сургалтын тоогоор	Иж бүрэн сургууль 1 удаа, КШС 2 удаа	Команд штабын сургууль 4 сум, иж бүрэн сургууль 4 сум	Аймгийн Засаг даргын 2023 оны А/102 дугаар захирамжаар Дэлгэрхаан суманд Гамшгаас хамгаалах иж бүрэн сургууль, А/198 дугаар захирамжаар Батноров суманд, А/251 дугаар захирамжаар Дадал суманд, А/445 дугаар захирамжаар Баянмөнх суманд, А/523 дугаар захирамжаар Батширээт сумдад тус тус Гамшгаас хамгаалах команд штабын сургууль зохион байгуулж Гамшгийн эрсдэлийг бууруулах сангаас 18.1 сая төгрөгийг зарцууллаа. Дээрх дадлага сургуульд орон нутгийн Онцгой комисс, мэргэжлийн ангийн бүрэлдэхүүн нийт 301 алба хаагчийг хамруулсан.	100	100	
167	ЗДҮАХХАХТ 4.3.11.2. Сумдад гамшгаас хамгаалах иж бүрэн команд штабын сургууль, удирдах ажилтны сургалт зохион байгуулна.	4 сая	Зохион байгуулсан сургалтын тоогоор	11 удаа зохион байгуулсан	4 суманд Удирдах ажилтны сургалтыг зохион байгуулж онолын мэдлэг олгох	Гамшгаас хамгаалах иж бүрэн болон Команд штабын сургууль Дэлгэрхаан, Батноров, Дадал, Баянмөнх, Батширээт сумдад зохион байгуулах ажлын хүрээнд тус сумдын 101 удирдах ажилтанд сургалт зохион байгуулсан.	100	100	
168	ЗДҮАХХАХТ 4.3.11.3. Аймгийн Засаг даргын нэрэмжит бэлэн байдлын үзлэгийг бүх сумд тосгодод 8 удаа зохион байгуулна	2 сая	Бэлэн байдлын үзлэг зохион байгуулсан тоогоор	18 сум, 4 тоснонд зохион байгуулсан	Сумдын ой хэрийн түймэртэй тэмцэх бэлтгэл бэлэн байдлыг хангуулан хүн хүч, техник хэрэгслийн тодотгол хийж бэлэн байдалд оруулах	Аймгийн Засаг даргын 2023 оны А/164 дугаар захирамжаар Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах бэлэн байдлын үзлэгийг 18 сум 4 тосгодод зохион байгуулсан. Уг арга хэмжээнд 810 орчим иргэнийг хамруулсан. тус бүр нэг удаа нийт 22 удаа зохион байгуулсан.	90	90	
Зорилт 4.3.13. Гамшгийн аюулын үед харилцан ажиллах дадлага, харилцаа холбоог сайжруулах, иргэдэд гамшиг аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх мэдээ мэдээллийг шуурхай хүргэх нөхцлийг бүрдүүлнэ.									

169	ЗДҮАХХАХТ 4.3.13.1 Гамшгийн аюулын үед харилцан ажиллах дадлага, харилцаа холбоог сайжруулах, иргэдэд гамшигт аюултай үзэгдлээс Урьдчилан сэргийлэх арга хэмжээг ард иргэдэд түргэн шуурхай хүргэх, гамшгийн голомтоос холбоо зохион байгуулалтын арга хэмжээг сайжруулан ажиллана.	5 сая	Холбоо зохион байгуулалтын бэлэн байдал хангагдсан байна.	Гамшиг осолтой тэмцэх бэлэн байдлыг хангуулах	Онцгой байдлын газрын гамшиг осолтой тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ дээшилсэн байна.	Гамшиг ослоос урьдчилан сэргийлэх болон үйл ажиллагааны холбогдолтой мэдээ мэдээллийг байгууллагын www.nema.khe.gov.mn вэб сайт болон Өндөрхаан телевиз, Аруухан.мн сайт, байгууллагын фэйсбүүк хуудсаар тухай бүр нь ард иргэдэд хүргэж, үйл ажиллагааг сурталчлан 79 мэдээ мэдээлэл, 73 орчим сэрэмжлүүлэг анхааруулга, шторк видеог 41 удаа хүргэж ажилласан бөгөөд Хэнтий аймгийн Засаг даргын тамгын газрын www.khentii.mn цахим сайтаар дамжуулан төрийн болон төрийн бус байгууллагуудын цахим хаягуудаар түгээж ажилласан. Иргэдэд түгээсэн мэдээ мэдээлэл давхардсан тоогоор 36124 мянган иргэнд хүрч ажилласан байна. ОБЕГ, БОАЖГазруудаас нисгэгчгүй нисэх төхөөрөмж /дорнн-1, гар станц 5 ширхэг, Дахин дамжуулах станц-1, Иридиум утас-1 нийт 8 холбооны тоног төхөөрөмжүүдийг шинэчлэн гамшгийн голомтод холбоо зохион байгуулах боломжийг нэмэгдүүлж ажилласан.	100	100
170	ЗДҮАХХАХТ 4.3.13.2 Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх талаар ард иргэдэд мэдээлэх багц мессэж үйлчилгээг хэрэгжүүлнэ.	3 сая	Иргэдэд хүргэсэн багц мессэжийн тоогоор	188402 иргэнд багц мессэж хүргэсэн.	Тухай бүрт гамшгийн голомтод байгаа иргэдэд мэдээлэл хүргэсэн байна.	2023 он гарснаас хойш цаг агаарын аюулт үзэгдлийн болон сэрэмжлүүлэг мэдээ мэдээллийг SMS sender программаар Багц-мессэжийг 12 удаагийн давтамжтай давхардсан тоогоор 74530 хүнд хүргэж ажилласан.	100	100
Зорилт 4.3.14. Хугацаат цэргийн албан хаасан иргэдийг сурч боловсрох, ажлын байранд зуучлах, төрийн албанд орох, нийгмийн суурь судалгаанд хамруулан халамжид хамрагдахад дэмжлэг үзүүлнэ.								
171	ЗДҮАХХАХТ 4.3.14.1. Хугацаат цэргийн албанаас халагдсан иргэдийг хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах их, дээд сургуулиудтай холбоно.	-	Их, дээд сургуульд зуучилсан %-иар	10%	15%	Их, дээд сургуулиас оюутан сурагч элсүүлэх талаар албан бичиг ирүүлсний дагуу залуучуудад зар хүргүүлж ажиллаж байгаа бөгөөд аймгийн ЗДТГ-ын даргаар ахлуулсан "Зегийн үүр" ажлын хэсэг байгуулагдан төлөвлөгөө гарган ажиллаж, хугацаат цэргийн албанаас халагдсан дайчдаас 2 иргэн хөнгөлөлттэй нөхцөлөөр суралцуулах талаар их, дээд сургуулиудтай холбон хамтран ажилласан.	30	30

172	ЗДҮАХХАХТ 4.3.14.2. Хугацаат цэргийн алба хаасан иргэдийг Уул уурхай, зам барилгын мэргэжил олгох 14 хоногийн хугацаатай сургалтад хамруулан сертификат олгуулж, бүтээн байгуулалтын ажилд зуучилна.	-	Ажилд зуучилсан %-иар	20%	40%	2023 оны 1, 2 дугаар ээлжээр хугацаат Цэргийн албанд татагдсан залуучуудаас 25% тухайн анги байгууллагатаа тусгай мэргэжил олгох сургалтад хамрагдсан бөгөөд хөдөлмөр, халамжийн газарт ирсэн ажлын байрны захиалгын дагуу 2 иргэнийг ШШГГ-т хянагчаар оруулж, 3 иргэнийг хүнд машин механизмын дамжаанд суралцуулсан Бор-Өндөр суман дахь УБҮ-ээс ирүүлсэн ажлын байранд зуучилж ажилласан.	90	70
173	ЗДҮАХХАХТ 4.3.14.3 Хугацаат цэргийн албанаас халагдсан иргэдийг болзол хангасан иргэдийн төрийн албанд ажиллуулах талаар Төрийн албаны салбар зөвлөлд бүртгүүлэх, шалгалтад ороход дэмжлэг үзүүлэх	-	Судалгаанд хамрагдсан %-иар	10%	20%	Төрийн албаны шалгалт өгөхөөр бүртгүүлж байгаа залуучуудад "Төрийн албаны болон Цэргийн албаны тухай хуулийн хүрээнд хяналт тавьж, нийт шалгалтад хамрагдах иргэдийн 15% нь бичиг баримтын үзлэг явуулан шаардлага хангаж байгаа залуучуудыг шалгалт өгөх боломжоор ханган ажилласан байна.	90	70
174	ЗДҮАХХАХТ 4.3.14.4 Хөдөлмөр, халамж үйлчилгээний газартай хамтран хугацаат цэргийн албанаас халагдсан иргэдийг нийгмийн суурь судалгаанд хамруулна.	-	Судалгаанд хамрагдсан %-иар	50%	70%	Жил бүрийн ээлжит цэрэг татлагаар хугацаат цэргийн албанаас халагдан ирж байгаа залуучуудыг хамруулдаг бөгөөд 2023 онд халагдаж ирсэн дайчдыг хөдөлмөр халамжийн, үйлчилгээний газартай хамтран ажилд зуулчлах болон холбогдох 100 хувь судалгаанд хамруулж ажилласан.	100	100
Зорилт 4.3.15. Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөөний дагуу нөөц бүрдүүлэх, сэдэвчилсэн сургалт зохион байгуулна.								
175	ЗДҮАХХАХТ 4.3.15.1 Орон нутгийн хамгаалалтын нөөц бүрдүүлэх талаар санал бэлтгэн аймаг, сумдын төсөвт суулгах	-	Нөөц бүрдүүлэлт иар	20%	60%	Сумдын Засаг дарга нарт Орон нутгийн хамгаалалтын томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэхэд шаардлагатай нөөц бүрдүүлэлт хийх, орон нутгийн төсөвт шаардлагатай зардлыг оруулах талаар чиглэл өгч ажилласны үр дүнд 4*8, 3*3 хэмжээтэй цэргийн зориулалттай платка 2 ширхгийг, хээрийн зориулалттай эвхдэг ширээ, сандал 3 комыг тус тус бэлтгэж материаллаг баазаа бэхжүүлсэн. Мөн сумдын төсөвт тус бүр 1 сая төгрөгийг тусгуулж нийт төлөвлөгөөт нөөц бүрдүүлэлтийг 80 хувь биелүүлсэн.	90	90

176	ЗДҮАХХАХТ 4.3.15.2. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бие бүрэлдэхүүний тодотголыг тогтоосон хугацаанд хийж нөхөн томилгоожуулах	-	тодотгол хийсэн эсэх	2021 оны 5, 11 дүгээр саруудад явуулж томилгоот бүрэлдэхүүний үүрэг гүйцэтгэх боломжийг бүрэн хангаж ажилласан	Тогтоосон хугацаанд тодотголыг хийж хэвшсэн байна.	Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжүүдийн бие бүрэлдэхүүний тодотголыг хүн, хүч техникийг татан оролцуулах бэлтгэл бэлэн байдлыг хангах зорилгоор 2023 оны 5 болон 11 дүгээр сард бүрэн хэмжээний тодотгол хийсэн.	100	100	
177	ЗДҮАХХАХТ 4.3.15.3. Томилгоот нэгжүүдийн сургалтыг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай хамтран зохион байгуулах	12 сая	нийт хамрагдах албан хаагчийн хувиар	Сумдыг бүсчлэн хувааж жил бүр хийж хэвшүүлэх	Төлөвлөгөөний дагуу сургалт хийгддэг болсон байна.	Цэргийн штабын 2023 оны сургалт бэлтгэлийн нэгдсэн төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хуваарийн дагуу "Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө"-ний томилгоот нэгжийн сургалтыг Хилийн цэргийн 0287, Зэвсэгт хүчний 232 дугаар анги, сумдын цагдаагийн тасагтай хамтран Биндэр, Баян-Адарга, Дадал сумдад зохион байгуулж ажилласан.	100	100	
Зорилт 4.3.16. Улсын болон цэргийн дайчилгааны төлөвлөгөөний дагуу албан байгууллага, иргэдийг даалгаваржуулж, тогтоосон хугацаанд тодотголыг явуулна.									
178	ЗДҮАХХАХТ 4.3.16.1 Улсын болон цэргийн дайчилгааны даалгаврын дагуу төлөвлөгөөг шинэчлэн боловсруулж, батлуулах	-	Төлөвлөгөөг батлуулсан эсэх	2004 оноос хойш хигдэж байгаагүй	70%	Улсын дайчилгааны төлөвлөгөөг боловсруулах ажлын хүрээнд аймаг орон нутагтай холбоотой мэдээллийг цуглуулан бэлтгэл ажил 80%-тай явагдаж байна. Цэргийн дайчилгааны төлөвлөгөөг бүрэн хийж дуусган ЗХЖШ-ын даргаар батлуулан хэрэгжүүлэн ажиллаж байна.	100	100	
179	ЗДҮАХХАХТ 4.3.16.2 Улсын болон цэргийн дайчилгааны даалгаварын дагуу иргэд, эд хөрөнгө, албан байгууллагыг оногдуулан данслаж, даалгаваржуулах	-	даалгаваржуулж дансалсан байдал %-иар		70%	Улсын болон цэргийн дайчилгааны төлөвлөгөөний дагуу албан байгууллага, иргэд, эд хөрөнгийг оногдуулан дансалж, 100 хувь даалгаваржуулсан.	100	100	
Зорилт 4.3.17. Цэргийн бүртгэлийн цахим системийг нэвтрүүлж, сумдыг холбоно.									
180	ЗДҮАХХАХТ 4.3.17.2 Сумдын ЗДТГ-тай онлайн холболт хийж, иргэн, цэргийн үүрэгтний, шилжилт хөдөлгөөн зэрэг мэдээллийг шуурхай солилцох		хувиар		Онлайнаар холбогдох 80%	E-Mongolia аппликэйшин болон бусад онлайн сүлжээг ашиглан сумдын ЗДТГ-тай групп чат үүсгэн холбогдох мэдээллийг 100% шуурхай солилцон ажиллаж байна.	90	100	

Зорилт 4.3.18. “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх” арга хэмжээг хэрэгжүүлж аймгийн Политехник коллежид “Оюутан-Цэрэг” сургалтыг зохион байгуулна.

181	ЗДҮАХХАХТ 4.3.18.1 Аймгийн хэмжээнд Ерөнхий боловсролын сургуулиудад "Дайчин алдар"-ын булан байгуулах ажлыг үргэлжлүүлэх	1.2 сая	Хийгдсэн хувиар	70%	80%	Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй ЕБС-уудыг 100% дайчин алдрын булантай болгосон.	100	100
182	ЗДҮАХХАХТ 4.3.18.2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Цэрэгжлийн спортын "Дөл" тэмцээнийг жил бүр зохион байгуулж, улсын аваргад оролцох	20 сая	Тэмцээн зохион байгуулсан эсэх	*	Тэмцээн зохион байгуулсан байна.	Аймгийн аварга шалгаруулах Цэрэг-спортын "ДӨЛ" цогцолбор тэмцээнийг 09 дүгээр сард амжилттай зохион байгуулсан бөгөөд уг тэмцээний тэргүүн байрт орсон Бор-Өндөр сумын ЕБС-ийн баг тамирчдыг 2024 онд Улсын аварга шалгаруулах цэрэг-спортын "Дөл" тэмцээнд оролцуулахаар болсон.	100	100
183	ЗДҮАХХАХТ 4.3.18.3. Политехник коллежд цэрэгжлийн танхим байгуулах, "Оюутан цэрэгт цэргийн мэргэжил олгох сургалт"-д хамруулах	4.0 сая	хамрагдсан сурагчдын хувиар	*	15%	Батлан хамгаалахын Сайдын 2023 оны А/96 дугаар тушаалаар Хэнтий аймагт үйл ажиллагаа явуулж буй Политехникийн коллежийн сурагчдаас 10 оюутныг "оюутан-цэрэг" хөтөлбөрт хамруулж Зэвсэгт хүчний 327 дугаар ангитай хамтран сургалт, дадлагыг 2023 оны 06 дугаар сарын 02-ноос 08 дугаар сарын 19-ны хооронд зохион байгуулж хөтөлбөрийг амжилттай 100 хувь хэрэгжүүлсэн. Мөн Политехникийн коллежийн хичээлийн байранд цэрэгжлийн танхимыг 2021 онд 100 хувь ашиглалтад оруулж оюутан цэргийн сургалтыг зохион байгуулан ажиллаж байна.	100	50

ТАВ. НОГООН ХӨГЖИЛ

Цэвэр орчин-ногоон бүс

Зорилго 5.1. Байгаль орчныг хамгаалах, орчны бохирдол, доройтлыг бууруулж нөхөн сэргээнэ.

Зорилт 5.1.1. Чингис хотын агаар, хөрсний бохирдлыг бууруулах менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлнэ.

184	ЗДҮАХХАХТ 5.1.1.1 Чингис хотын агаарын чанарын бүс тогтоож, бүсэд мөрдөх журам батлуулж, агаарын бохирдлыг бууруулах менежментийн төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлнэ.		хэрэгжилтийн хувиар	Агаарын чанарын бүс тогтоож, бүсэд мөрдөх журам боловсруулсан.	Агаарын чанарын бүсэд мөрдөх журмын 1-р үе шатны хэрэгжилт 50 хувь хангагдсан байна.	Батлагдсан агаарын чанарын бүсэд мөрдөх журмыг khentii.mn сайтад байршуулж, хэрэгжилтийг хангах хүрээнд бүсэд хамаарах усан болон уурын халаалтын зуух, аж ахуйн нэгжүүдэд хүргүүлж мөрдөж ажиллах чиглэл өгсөн. Журамд заасны дагуу иргэд, айл өрхүүдэд агаарын бохирдлыг бууруулах, гэр байр сууцны дулаан алдагдлыг бууруулах, утаагүй зуух, цахилгаан халаалт зэргийг танилцуулах нөлөөллийн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, орон сууцыг нэмэгдүүлж, сумдыг төвлөрсөн халаалттай болгож, айл өрхүүдийн хэрэглээнд боловсруулсан түлш, байгалийн хий болон цахилгаан халаалтыг өргөнөөр нэвтрүүлэх ажлуудыг дэмжиж НҮБ-тай хамтран 49 өрхийг гэрийн дулаалга, агаар сэлгэлт, цахилгаан халаагуурын чип багцад хамруулсан. Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд ердийн болон нам галлагаатай зуухны тоо багасаж, түүхий нүүрсний хэрэглээ буурч, агаарын чанарын бүсэд мөрдөх журмын хэрэгжилт 50 гаруй хувьтай хангагдаад байна.	100	100
185	ЗДҮАХХАХТ 5.1.1.2 Чингис хотын хог хаягдлын менежментийн төлөвлөгөө боловсруулж, хөрсний бохирдлыг бууруулна.	130.9	хэрэгжилтийн хувиар	Чингис хотын хог хаягдлын менежмент төлөвлөгөө боловсруулсан.	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт 40 хувь хангагдаж, хөрсний бохирдол буурсан байна.	Аймгийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах хүрээнд Чингис хотод 13 ажил арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж, 2023 оны төлөвлөгөөний хэрэгжилтийг 93 хувьтай хангаад байна. Бүх нийтийн их цэвэрлэгээг хот суурин газар болон усан сан, усны эх үүсвэр бүхий газрын онцгой болон энгийг хамгаалалтын бүсэд, авто зам дагуу болон аялал жуулчлалын гол маршрутын дагуух газруудад 18 сумын хэмжээнд 5640 тн ил задгай хог хаягдлыг цэвэрлэж, төвлөрсөн хогийн цэгт зөөж, дарж булшлан, 3000 гаруй га талбай дахь хөрсний бохирдлыг буурууллаа. 8 суманд стандартын шаардлага хангаагүй хөрс бохирдуулагч 114 нүхэн жорлонг буулгаж, 15 муу усны нүхийг булж устган, амралт, сувилал, наадмын талбай, голын эрэг дагуу 25 эко жорлон, 10 био жорлон суурилуулж, хөрсний бохирдлыг буурууллаа.	100	100

186	ЗДҮАХХАХТ 5.1.1.3. Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллого зохион байгуулж, агаарын чанарын мониторинг хяналтыг тогтмолжуулна.	2.0	хэрэгжилтээр	Жил бүр хийгдэж, суурь мэдээллийн сан бий болсон.	Тооллогын ажил зохион байгуулагдаж, үр дүнд анализ хийгдсэн байна.	Агаарын бохирдлын эх үүсвэрийн нэгдсэн тооллогыг 18 сум 5 тосгоны хэмжээнд зохион байгуулж нэгтгэл үр дүнг хуулийн хугацаанд багтаан БОАЖЯаманд хүргүүлсэн. Аймгийн хэмжээнд нийт 3-15кВт хүчин чадалтай буюу ердийн галлагаатай зуух 6856 тоологдсоноос, сайжруулсан зуух 587, 15-100кВт хүчин чадалтай нам даралтын зуух 131, 100-4200кВт хүчин чадалтай усан болон уурын зуух 37, 4200кВт-аас дээш хүчин чадалтай зуух 3 ширхэг тоологдсон. Тооллогын дүнг өмнөх онтой харьцуулахад ердийн галлагаатай зуухны тоо 168-аар буюу 2.4%-аар, нам даралтын буюу 15-100кВт хүчин чадалтай зуухны тоо 84-өөр буурсан бол 100-4200кВт хүчин чадалтай зуух 9-өөр нэмэгдсэн байна. Чингис хотын агаарын чанарын хяналтын үр дүнг сайжруулах зорилгоор Япон улсад үйлдвэрлэсэн SIBATA фирмийн агаараас дээж соруулах 2 төрлийн тоног төхөөрөмжийг УЦУОШТ-ийн Байгаль орчны шинжилгээний лабораторид нийлүүлж агаарын чанарын хяналтад ашиглаж байна.	100	100
Зорилт 5.1.2. Шахмал түлшний хэрэглээг нэвтрүүлж, "Эко өрх", "Өрх бүр ногоон төгөл" аяныг өрнүүлж гэр хорооллын айл өрхүүдийн 50 хүртэл хувийг хамруулснаар агаар хөрсний бохирдлыг тус тус 30 хүртэл хувиар бууруулна.								
187	ЗДҮАХХАХТ 5.1.2.1 "Эко өрх", "Өрх бүр ногоон төгөл" аяны төлөвлөгөөг гарган хэрэгжилтийг хангаж ажиллана.	-	хувиар	нийт өрхийн 20 хүртэл хувийг аянд хамруулсан.	нийт өрхийн 30-аас доошгүй хувийг аянд хамруулна.	Тэрбум мод үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд "Өрх бүр ногоон төгөл" аяныг сум бүрт зохион байгуулахыг уриалж, 2300 гаруй айл өрх хашаандаа 17000 гаруй мод бут тарьж, Хэрлэн суманд модны суулгац, хүнсний ногооны үр үрсэлгээ хөнгөлөлттэй үнээр худалдах арга хэмжээнд 400 гаруй өрх хамрагдаж, нийт өрхийн 21.3% хамрагдлаа.	70	70
188	ЗДҮАХХАХТ 5.1.2.2 Шахмал түлш үйлдвэрлэх, худалдаалах иргэн, аж ахуйн нэгж байгууллагын санал санаачлагыг дэмжиж, түүхий нүүрсний хэрэглээг бууруулна.	-	хэрэгжилтээр	3 суманд тоног төхөөрөмж нийлүүлсэн.	Шахмал түлшийг борлуулах, худалдаалах цэг бий болгож, хэрэглээнд нэвтрүүлж эхэлсэн байна.	"Хаягдал цаасыг дахин ашиглаж, шахмал түлж хийх" иргэний санаачилсан гарааны бизнесийн төслийг дэмжиж, 2 тн хаягдал цаасыг боловсруулан шахмал түлш хийж эдийн засгийн эргэлтэд оруулаад байна. Сумдад болон Чингис хотод орон сууцнууд шинээр ашиглалтад орж, инженерийн шугам сүлжээ, суурьшлын бүсийн цахилгаан эрчим хүчийг нэмэгдүүлснээр ердийн болон нам галлагаатай зуухны тоо	100	70

						багасаж, түүхий нүүрсний хэрэглээ 8.7%-аар буураад байна.		
<p align="center">Зорилт 5.1.3. Хогны менежментийг үр дүнтэй хэрэгжүүлж, хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд хэвшүүлж, дахин боловсруулах боломжтой хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулах замаар төвлөрсөн хогийн цэгт очих хог хаягдлын хэмжээг 40 хүртэл хувиар бууруулна.</p>								
189	ЗДҮАХХАХТ 5.1.3.1. Хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах ажлыг иргэд, аж ахуйн нэгжүүдийн дунд хэвшүүлэх, сургалт, мэдээлэл, нөлөөллийн ажлуудыг жил бүр зохион байгуулна.	2.0	тоогоор	Сургалт, нөлөөллийн ажлыг сар бүр зохион байгуулсан.	Сургалт, нөлөөллийн ажлыг 1-ээс доошгүй удаа зохион байгуулсан байна.	Хог хаягдлын менежментийг иргэдэд сурталчлан таниулах зорилгоор "Хог биш баялаг" ТББ-тай хамтран сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулж 200 гаруй иргэд, хүүхэд залуус, сайн дурын ажилчид, олон нийтийн байцаагчид болон төрийн байгууллагын үйлчлэгчдийг хамруулсан. Мөн аймгийн төвийн 5 сургуулийн эко клубийн 94 сурагчдад хог хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгах сургалтыг хийсэн.	100	100
190	ЗДҮАХХАХТ 5.1.3.2. Сумдад хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр хангана	245 сая	тоо, хувиар	4 суманд хогны менежментийг хэрэгжүүлж, техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн.	2-оос доошгүй суманд хогны менежментийг хэрэгжүүлж, техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлж, дахивар хог хаягдлын хэмжээ 20 хүртэл хувиар буурсан байна.	2023 онд 17 суманд хог хаягдлыг тээвэрлэх, цуглуулах, шатаах зэрэг 36 техник тоног төхөөрөмжийг нэмэгдүүлсэн. Дадал суманд АХБанкны санхүүжилтээр хог хаягдлын 2-р зэргийн лансфил төвлөрсөн цэг ашиглалтад орж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангагдаад байна. Хэрлэн сумын хог хаягдлын менежментийг сайжруулах зорилгоор 2тн/хоног хүчин чадалтай хог хаягдал шатаах зуух худалдан авч, Чингис дагуу дахивар хог хаягдлыг цуглуулах, дахин боловсруулах зорилготой цэгийг байгуулж шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж тохижуулсан. Чингис хот, Бор-Өндөр суманд хуванцар, шил, лааз, гялгар уут, хайлш, цаас зэрэг дахивар хог хаягдлыг ангилан ялгаж преслэн, дахин боловсруулах үйлдвэрт нийлүүлж, хаягдал цаасаар шахмал түлш үйлдвэрлэх үйл ажиллагаа явуулж, 28.4 тн хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулан хаягдлын хэмжээг 15.7 хувиар буурууллаа.	70	70
<p align="center">Зорилт 5.1.4. Төв суурин газрын ногоон байгууламжийн эзлэх талбайн хэмжээг жил бүр нэмэгдүүлж, нийт 65 га-д хүргэнэ.</p>								

191	ЗДҮАХХАХТ 5.1.4.1 "Бүх нийтээр мод тарих үндэсний едөр"-ийг жил бүр зохион байгуулж, аймгийн ногоон байгууламжийн талбайн хэмжээг 20 га талбайгаар нэмэгдүүлж нийт 65 га-д хүргэнэ.	135 сая	нэмэгдсэн га талбайн хэмжээгээр	Аймгийн нийт ногоон байгууламжийн талбайн хэмжээ 80.5 га	ногоон байгууламжийн талбайн хэмжээг 5 га - аар нэмэгдүүлнэ.	Тэрбум үндэсний хөдөлгөөн болон Бүх нийтээр мод тарих арга хэмжээний хүрээнд хот суурингийн ногоон байгууламжид нийт 209.6 мянган ширхэг мод таригдаж, ногоон байгууламж 65 га талбайгаар нэмэгдсэн.	100	100
192	ЗДҮАХХАХТ 5.1.4.2 Чингис хотын нийтийн эзэмшлийн талбайд зүлэгжүүлэлт хийж хөл газрын ургамлын талбайн хэмжээг бууруулж, ногоон байгууламжид арчилгаа хийнэ.		га талбайн хэмжээгээр	2022 онд 0.9 га талбайг зүлэгжүүлсэн.	Нийтийн эзэмшлийн 1 га талбайд зүлэгжүүлэлт хийж ногоон байгууламжийг арчилна.	Чингис хотын нийтийн эзэмшлийн талбайд хөл газрын ургамлын хэмжээг бууруулах, иргэдийн амьдрах орчны ая таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Төв цэнгэлдэх хүрээлэн, Сэцэн хааны ордон музей, АЗДТГ-ын гадна талбай, нийт 6.1 га талбайд зүлэгжүүлэлтийн ажил хийгдсэн.	100	90
Зорилт 5.1.5. Аймгийн хэмжээнд 1000 га талбайд ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж, нийт ойн сангийн ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг 0.05 хувиар нэмэгдүүлнэ.								
193	ЗДҮАХХАХТ 5.1.5.1. Жил бүр ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг хийж, ойгоор бүрхэгдсэн талбайн хэмжээг нэмэгдүүлнэ		га талбайн хэмжээгээр	Ойжуулалтын ажлыг 222.5га талбайд хийсэн.	Ойжуулалт, байгалийн сэргэн ургалтад туслах ажлыг 250 га талбайд хийнэ.	Улсын төсвийн хөрөнгөөр Дадал, Баян-Адарга сумдад нийт 90 га талбайд байгалийн сэргэн ургалтад туслах ажил, ой бүхий Цэнхэрмандал, Батширээт, Биндэр, Дадал, Норовлин, Дэлгэрхаан сумдад Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал болон ойн мэргэжлийн байгууллагын өөрийн хөрөнгөөр нийт 212 га талбайд ойжуулалтын ажил тус тус зохион байгуулж, нийт 302 га талбайд ойг нөхөн сэргээж, ойжууллаа.	100	100

194	ЗДҮАХХАХТ 5.1.5.2. Ойн хөнөөлт шавжийн идэвхжилээс шалтгаалан голомт үүссэн талбайн 50-аас доошгүй хувьд нь тэмцлийн ажлыг зохион байгуулж ойг доройтлоос хамгаална.		хэрэгжилтээр	Ойн хөнөөлт шавьжийн тэмцлийн ажлыг 3378 га голомттой талбайн 55.5 хувьд хийж гүйцэтгэсэн	Тухайн жилийн голомт үүссэн талбайн 50-аас доошгүй хувьд тэмцлийн ажлыг зохион байгуулна.	Улсын төсвийн хөрөнгөөр Цэнхэрмандал суманд 3000 га, Биндэр суманд 2000 га, Өмнөдэлгэр суманд 3000 га, Батширээт суманд 3000 га, орон нутгийн төсвийн хөрөнгөөр Цэнхэрмандал суманд 200 га, Биндэр суманд 400 га, Батширээт суманд 200 га, нийт 11800 га талбайд хими болон бактерийн бэлдмэлээр ойн хөнөөлт хортон шавжийн тэмцлийн ажлыг зохион байгуулж ойг доройтлоос хамгааллаа. Нийт голомттой талбайн 50-аас доошгүй хувьд жил бүр тэмцлийн ажил хийж байна.	100	100
Зорилт 5.1.6. Цэнгэг усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх, түүний ай сав газар, ховор ан амьтан, ургамлын тархац нөөц бүхий байгалийн унаган төрхийг хадгалж хамгаалах, экосистемийн ач холбогдол бүхий газруудыг улсын болон аймаг, орон нутгийн тусгай хамгаалалтад авах ажлыг зохион байгуулж, нийт нутаг дэвсгэрийн 47 хувьд хүргэнэ.								
195	ЗДҮАХХАХТ 5.1.6.1. Усны ай сав бүхий болон экосистемийн ач холбогдол бүхий газрыг улсын болон орон нутгийн хамгаалалтад авна		хувиар	44.6	46	Өмнөдэлгэр сумын Тэнүүн гол орчмын 119.9 мянган га талбай бүхий газрыг байгалийн нөөц газрын ангиллаар орон нутгийн тусгай хамгаалалтад авч Кадастрын нэгдсэн бүртгэлд бүртгүүлснээр нийт нутаг дэвсгэрийн 46.3%-ийг улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газар эзэлж байна.	100	100
Зорилт 5.1.7. Амьтны нөөцийг хамгаалах, өсгөж үржүүлэх, зохистой ашиглах менежмент зохион байгуулалтыг хийж, ховор амьтдын тоо толгойг 3 хүртэл хувиар өсгөнө.								
196	ЗДҮАХХАХТ 5.1.7.1 Ховор, нэн ховор амьтдыг хамгаалах, идэш тэжээлээр хангах био техникийн арга хэмжээ авна.		тоогоор	13 суманд био техникийн арга хэмжээ авсан.	Жилд 4-өөс доошгүй суманд био техникийн арга хэмжээ авсан байна.	Мөрөн, Жаргалтхаан, Дадал, Хэрлэн, Баянхутаг, Баянмөнх, Биндэр, Өмнөдэлгэр, Дархан, Норовлин, Баян-Адарга, Батширээт, Бор-Өндөр, Дэлгэрхаан, Галшар сумдын ЗДТГазрууд байгаль хамгаалан нөхөн сэргээх зардлаар нэн ховор, ховор амьтан байршин нутагладаг агнуурын бүс нутгуудад 1120 боодол ногоон тэжээл, 1790 боодол өвс, 150 кг ашигт долооц, 50 кг хивэг, 47.9 тн хужир шүүг тавьж биотехникийн арга хэмжээ авч ажилласан.	100	100

197	ЗДҮАХХАХТ 5.1.7.2. Амьтны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, өсгөн үржүүлэх зорилгоор агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ.		тоогоор	2 агнуур зохион байгуулалтын менежмент төлөвлөгөө хийгдсэн.	Жил бүр 1-ээс доошгүй агнуур зохион байгуулалтын менежмент төлөвлөгөө боловсруулж батлуулсан байна.	Батширээт сумын Засаг даргын Тамгын газар байгаль хамгаалах нөхөн сэргээх зардлын 7,0 сая төгрөгөөр байгаль орчны мэргэжлийн байгууллагатай гэрээ хийж "Ононгийн арал шувуу агнуурын бүс" болон "Хавтгар агнуурын бүс" нутгийн нарийвчилсан агнуур зохион байгуулалт менежмент төлөвлөгөөг хийж гүйцэтгүүлж, БОАЖЯаманд батлуулахаар хүргүүлсэн.	90	90
-----	--	--	---------	---	---	--	----	----

Зорилт 5.1.8. Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг хангаж, 80-аас доошгүй булаг, шандны эхийг хашиж хамгаална.

198	ЗДҮАХХАХТ 5.1.8.1 Усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийн хэрэгжилтийг сайжруулах зорилгоор 120-оос доошгүй тэмдэг тэмдэгжүүлэлт хийнэ.	30 сая	тоогоор	Усан сан бүхий газрын энгийн болон онцгой хамгаалалтын бүсээр 50 тэмдэг байршуулсан.	30-аас доошгүй тэмдэгжүүлэлт хийгдсэн байна.	Онон-Улз, Хэрлэн, Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газруудад усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсэд дэглэмийг мөрдүүлэх зорилгоор 60 ш тэмдэгжүүлэлт хийж байршуулсан.	100	100
199	ЗДҮАХХАХТ 5.1.8.2 Шаардлагатай булаг шандын эхийг хашаажуулах, сэргээн засах ажлыг зохион байгуулна.	50 сая	тоогоор	20 булгийн эхийг хашиж хамгаалсан.	20-оос доошгүй булгийн эхийг хашиж, сэргээн зассан байна.	Онон-Улз, Хэрлэн, Умард говийн гүвээт-халхын дундад талын сав газруудад хамаарах 8 сумдад 12 булгийн эхийг хаших ажлын БХНСЗардлаар гүйцэтгүүлсэн.	70	70

Зорилт 5.1.9. Элэгдэл, эвдрэлд орж эзэнгүй орхигдсон газар, түүний хэвлийд техникийн нөхөн сэргээлт ажлыг 80 га газарт хийнэ.

200	ЗДҮАХХАХТ 5.1.9.1. Эзэнгүй орхигдсон газрын хэвлийг нөхөн сэргээх арга хэмжээг зохион байгуулна.	20 сая	га талбайн хэмжээгээр	30 га газарт нөхөн сэргээлт хийсэн.	Уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн орхигдсон 25 га-талбайд техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийгдсэн байна.	ОНТ-ийн БХНСЗардлаар Цэнхэрмандал сумын Хэрлэнгийн гүүр нэртэй уул уурхайн нөлөөгөөр эвдэрсэн 10 га талбайд, Хэрлэн суманд дулааны энгэр нэртэй 1.2 га талбайд техникийн нөхөн сэргээлтийг хийсэн. Батноров, Хэрлэн, Норовлин, Өмнөдэлгэр сумдад баригдаж буй авто замын засвар, бүтээн байгуулалтын ажилд ашиглагдсан замын карьерын нөхөн сэргээлтийг 100.5 га талбайд хийлгээд байна.	100	100
-----	--	--------	-----------------------	-------------------------------------	---	--	-----	-----

ЗУРГАА. АЙМГИЙН ТӨВ, СУМ ТОСГОДЫН ХӨГЖИЛ

6.1 Чингис хот

Зорилт 6.1.1. Дулааны станцын гадна инженерийн хангамжийн ажлыг гүйцэтгүүлнэ.

201	ЗДҮАХХАХТ 6.1.1.1 Дулааны станцыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангагдана.		Ажлын гүйцэтгэлээр	70 хувь	Дулааны станцын гадна хангамжийн ажил дууссан байна.	Дулааны станцын холбоо дохиоллын ажлын зураг төсөв 2023 онд ахин магадлалаар хянагдаж баталгаажсан бол, гадна цахилгаан хангамжийн зураг төсөл, ариутгах татуурга инженерийн шугам сүлжээний ажлын зураг төсөл дууссан. Тус ажлууд нь 2024 оны улсын төсвөөр хэрэгжихээр батлагдсан байна.	70	70
Зорилт 6.1.2. Чингис хотын 2-р хэлхээний шугам сүлжээг үе шаттай гүйцэтгэнэ.								
202	ЗДҮАХХАХТ 6.1.2.1. 2-р хэлхээний засвар, шинэчлэлийн ажлыг үе шаттай гүйцэтгэнэ.		Ажлын гүйцэтгэлээр	2-р хэлхээний шугам сүлжээ шинэчлэгдэж, зуухны тноглол нэмэгдсэн	2р хэлхээний засвар, шийнэчлэлийн ажил үргэлжилнэ.	2-р хэлхээний засвар, шинэчлэлийн ажил дуусч 1, 3 дугаар зуухны барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажилласан байна.	100	100
Зорилт 6.1.4. Хэрлэн сумын 1 дүгээр багт хэрэгжиж байгаа гэр хорооллын дахин төлөвлөлтийн төслийг дуусгана.								
203	ЗДҮАХХАХТ 6.1.4.1. Төр, хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтыг дэмжинэ.		Барилгын ажил эхэлсэн эсэх	Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 90 айлын орон сууцны БУА эхлэх бэлтгэл ажил хангагдаж байна.	Төлөвлөлтийн дагуу шинээр орон сууц барих иргэн, аж ахуйн нэгжүүдэд шаардлагатай дэмжлэг үзүүлсэн байна.	1-р багийн иргэдийг орон сууцжуулах дахин төлөвлөлтийн төслийг эхлүүлэхээр гүйцэтгэгч бэлтгэл ажлыг хангаж, айл өрхүүдээс газраа чөлөөлөх зөвшөөрөл бүхий өргөдөл цуглуулах явц дуусах шатандаа явж байна. Дахин төлөвлөлтийн уурын зуухыг ашиглалтад оруулж 98 айлын орон сууцыг ашиглалтад оруулан дулааны шугамд холболоо. Мөн Чингис хотын жилийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 10 блок 1300 айлын орон сууцны эхний ээлжийн 250 айлын орон сууц барих төслийн сонгон шалгаруулалт хийгдэж санамж бичиг байгуулав.	100	70
Зорилт 6.1.5. Чингис хотын гэр хорооллын худгуудыг төвлөрсөн цэвэр усанд холбож, ухаалаг систем суурилуулна.								
204	ЗДҮАХХАХТ 6.1.5.1 Чингис хотын гэр хорооллын худгуудад ухаалаг систем суурилуулж, төвлөрсөн цэвэр усны шугамд холбоно.		Ажлын гүйцэтгэлээр	-	Чингис хотын гэр хорооллын 1 худагт ухаалаг систем суурилуулж төвлөрсөн цэвэр усны шугамд холбоно.	Чингис хотын гэр хорооллын ус түгээх байрнууд болох 3-р ус түгээх байр 16-р ус түгээх байрууд киоск худаг хийсэн ба ухаалаг систем суурилуулсан.	100	100
